



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО БҮРДСЭН БОЛОВЧ
ҮР НӨЛӨӨ БАГА БАЙНА**

**2023 оны 05
дугаар сар**

**АУДИТЫН СЭДЭВ: ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР
ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО,
ҮР НӨЛӨӨ**

2023 он

АГУУЛГА

АГУУЛГА	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Графикийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
А.Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан байна	7
А1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн байна	7
А1.1. Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны хууль эрх зүйн орчин бүрдсэн байна	7
А1.3.Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог үр дүнтэй зохион байгуулж ажилласан байна	10
Б.Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээний үр нөлөө бага байна	11
Б.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн боловч эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна	11
Б1.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн байна	11
Б1.2.Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж, гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна	14
Б1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын сонгон шалгаруулалтыг ЭМДЕГ-аас зохион байгуулсан байна	23
Б1.5. Өрх, сумын ЭМТ, төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 2022 оны гэрээг дүгнээгүй байна	25
Б1.6. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн шинэчилсэн бодлогын үр дүнд эрүүл мэндийн байгууллагуудад олгож байгаа санхүүжилт нэмэгдсэн боловч эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж байгаа үйлчилгээний чанарт ахиц гараагүй байна	29
Б.2.Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой түвшинд ахиц дэвшил гарч байна	35
Б2.1. Малчин, айл өрх эрүүл тусламж үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна	35
Б.2.2. Эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог хангах цахим системийн хөгжүүлэлт хангалтгүй байна	37
Б.2.3. Даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж, өргөдөл, гомдлыг шийдвэрлэж ажилласан байна	38
Б.3. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа үр нөлөөтэй байна	40
Б3.1 Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тайлагнаж ажилласан байна	40
Б3.2. Цахим программын хөгжүүлэлт, хүний нөөц дутмаг байдлаас шалтгаалж төлбөрийн нэхэмжлэлд бүрэн хэмжээгээр хяналт тавих боломж бүрдээгүй байна	43
Б.3.3. Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна	44
ДҮГНЭЛТ:	45
ЗӨВЛӨМЖ:	46
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	47

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дэд байгууллагын олон улсын стандарт
БНЭМХ	Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
СЯ	Сангийн яам
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл
ЭМДШ	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МУБИС	Монгол Улсын Багшийн их сургууль
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
СДЭ	Сум дундын эмнэлэг
ТУЗ	Төлөөлөн улирдах зөвлөл
ОХБ	Оношийн хамааралтай бүлэг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1	ЭМДС-ын орлогын 2021-2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	13
Хүснэгт 2	2021-2022 оны ЭМДШ-ын төвлөрүүлэлт	14
Хүснэгт 3	Шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэдийн 2021-2022 оны ЭМДШ-ын төвлөрүүлэлт	14
Хүснэгт 4	ЭМБ-ын 2021-2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал	15
Хүснэгт 5	ЭМБ-уудад 2021-2022 онд олгосон санхүүжилт	16
Хүснэгт 6	Лавлагаа шатны ЭМБ-ын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал	17
Хүснэгт 7	Анхан шатны ЭМБ-ын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал	18
Хүснэгт 8	Эмийн үнийн хөнгөлөлт олгох тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал	20
Хүснэгт 9	Вируст гепатит В,С вирусын эмийн олголт	21
Хүснэгт 10	Урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал	21
Хүснэгт 11	Коронавируст халдварын үеийн тусламж үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал.	22
Хүснэгт 12	ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/03 тоот тушаалын хавсралт	26
Хүснэгт 13	Эмийн сангуудын үнэлгээ	29
Хүснэгт 14	Эрүүл мэндийн байгууллагуудад 2020-2022 онд олгосон санхүүжилтийн гүйцэтгэл	30
Хүснэгт 15	Эрүүл мэндийн байгууллагуудын 2020-2022 оны тохиолдлын тоо.	31
Хүснэгт 16	Эрүүл мэндийн байгууллагуудад 2020-2022 оны цалингийн зардлын гүйцэтгэл	32
Хүснэгт 17	Эрүүл мэндийн байгууллагуудын 2020-2022 оны үндсэн хөрөнгө	32
Хүснэгт 18	Эрүүл мэндийн байгууллагуудын 2020-2022 оны үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй	33
Хүснэгт 19	Шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэдийн хамрагдалт	36

Графикийн товъёг

График №01	ЭМДШ-ийн 2021,2022 оны орлогын төлөвлөгөөний биелэлт	13
График №02	ЭМБ-уудын 2020-2022 оны цалингийн гүйцэтгэл	33
График №03	Шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн судалгаа 2021,2022 он	37

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах” тухай А/04 дүгээр тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэнэ.

Аудитын зорилт

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэнэ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитын гүйцэтгэнэ.Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх,
- Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх,

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд, эрүүл мэндийн хөгжлийн төв болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021-2022 оны үйл ажиллагааг хамруулав. Шүүхийн шийдвэртэй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй асуудлыг аудитад хамруулахгүй болно.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглан салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга, лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэнэ.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор У.Ербол, М.Айнур, аудитор Х.Манаргүл, С.Нурлан, К.Еркегүл нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн дотор ҮАГ-т, 05 дүгээр сарын 22-ны дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

Талбарын ажлыг гүйцэтгэх үе шатанд санхүүгийн тайлангийн аудит, бусад гүйцэтгэлийн аудиттай давхацсан тул хүн хүчний хүрэлцээ муугаас 3 хүний бүрэлдэхүүнтэй аудитын талбарын ажлыг гүйцэтгэсэн, 5 сарын 01-нээс хойш аудитад 2 аудиторов татан оролцуулж, зарим тулгалтуудыг хийлгэсэн болно. Аудитын хугацаа богино, хамрах хүрээ өргөн байсан тул аудитийн баг ачаалалтай ажиллав.

А.Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан байна

А1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн байна

А1.1. Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны хууль эрх зүйн орчин бүрдсэн байна

"Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын баримт бичгийн зорилт 2.2-т "Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ", зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүнг I үе шат (2021-2030): Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэл үе гэж тодорхойлж дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна Үүнд:

2-т "Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоотой болсон байна",

3-т "Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдсэн байна",

5-т "Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйл буурсан байна",

6-т "Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгал, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгох",

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.5-т "гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна", УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний 2.1.12-т "Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх" гэж тусгасан байна.

УИХ-аас 2016 онд батлагдсан Монгол Улсын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Азийн хөгжлийн банкны техник туслалцааны МОН 9701: "Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах төсөл" нь Сангийн яам, Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хэрэгжиж, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг эхлүүлсэн байна.

Дээрх төслийн үйл ажиллагаа нь стратегийн худалдан авалтыг бий болгох, нэг худалдан авагч тогтолцоонд шилжих, худалдан авагч байгууллагын чадавх болон улсын эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэгдсэн байна.

Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн чуулганаар Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, нэг худалдан авагчийн

тогтолцоо бий болох, стратегийн худалдан авалтыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.

Эрүүл мэндийн салбарын багц хуулиудад орсон өөрчлөлтөөр дараах асуудлуудыг хуульчилж өгсөн байна.

- **Эрүүл мэндийн санхүүжилтийн хүрээнд орсон өөрчлөлт:**

Өмнөх хуулиар төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг зардлын зүйл ангиар өмнөх жилийн санхүүжилтэд суурилан дараа жилийн улсын төсвийн санхүүжилтийг баталдаг, эмнэлгүүд нь улсын төсөв болон даатгал гэсэн 2 эх үүсвэрээс санхүүждэг, улсын төсвийн санхүүжилт тухайн тусламж, үйлчилгээг үзүүлсэн эсэхээс үл хамаардаг, ЭМДС үзүүлсэн тусламж, үйлчилгээний тохиолдлын тоогоор санхүүжилт олгодог ч санхүүжилт нь мөн л идэвхгүй хэлбэртэй байсан санхүүгийн эх үүсвэрийг нэгтгэж, зөвхөн тохиолдолд суурилсан аргаар санхүүжүүлэхээр болсон бөгөөд улсын төсвөөс эмнэлгүүдэд олгож байсан санхүүжилтийн эх үүсвэрээ ЭМДС-д нэгтгэж, ЭМДЕГ энэхүү нэгдсэн сангийн мөнгөөр эрүүл мэндийн байгууллагуудаас тусламж, үйлчилгээг худалдан авахаар зохицуулалт хийгдсэн байна.

Эрүүл мэндийн тухай хуульд заасан төр төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний жагсаалтыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тусгаж Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээнд нэмж хамруулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд орсон гол нэмэлт өөрчлөлт:

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад дараах тусламж, үйлчилгээ хамаарна: 9.1.5-т "Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.3 (хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төв), 15.1.8 (сувилал), 15.1.10 (сэргээн засах төв), 15.1.14 (сувилахуйн төв) заасан эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээ; 9.1.13-т "Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.1 (жирэмсэн, төрөлт, төрсний дараах үетэй холбоотой эх барихын тусламж, үйлчилгээний зардал), 24.6.2 (төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас хүүхдэд үзүүлэх эмнэлгийн зарим тусламж, үйлчилгээ), 24.6.5 (аргаагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврахаар яваад гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ), 24.6.6 (сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн эмгэгийн зарим эмчилгээ), 24.6.7 (удаан хугацааны нөхөх эмчилгээ шаардах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн зардал), 24.6.8 (бие махбодын ба бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэцийн сэргээн засах тусламж, үйлчилгээ), 24.6.10 (эмнэлгийн яаралтай болон түргэн тусламж, халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ), 35¹.3 (Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.4-т заасан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдаагүй энэ хуулийн 35¹.1-д заасан хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ)-т заасан тусламж үйлчилгээг ЭМДС-аас зардлын төлбөрийг хариуцахаар нэмэлт өөрчлөлт орсон байна. Үүний үр дүнд 2 санг нэгтгэн нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж, орцод суурилсан зардлын зүйл ангийн

санхүүжилтийг бүрэн халж, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг зөвхөн тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлэх боломж бүрдсэн байна.

- **Тусламж, үйлчилгээний чанарын хүрээнд орсон өөрчлөлт:**

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын асуудлын хүрээнд **Олон улсын эмнэл зүйн удирдамжийг** ашиглахаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7 дахь заалтад тусгаж, тусламж, үйлчилгээний чанарын талаар хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5-т “даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох”, 23 дугаар зүйлийн 23.2.3-т “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг энэ хуулийн 14.8.7-д заасан журмын дагуу цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэж тусгасан байна.

- **ЭМД-ын хязгаарлалтын асуудлын хүрээнд орсон өөрчлөлт:**

Даатгуулагчийн тусламж үйлчилгээний зардалд жилд 2 сая төгрөг хүртэл, оношилгоо, шинжилгээ хийлгэсэн тохиолдолд сард 55,000 төгрөг, улиралд 165,000 төгрөгийг ЭМДС-аас олгодог тусламж, үйлчилгээний хязгаарлалтыг хүчингүй болгож, даатгуулагчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.9.9 дэх заалтуудыг хүчингүй болгосон байна.

- **Цалин хөлс, урамшууллын хязгаарлалтын хүрээнд орсон өөрчлөлт:**

Эрүүл мэндийн ажилтны цалин хөлс, урамшууллыг Засгийн газрын шийдвэрийн дагуу тогтоодог байсныг ажлын бүтээмжид суурилан нэмэх боломжийг бий болгож, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.4-д өөрчлөлт оруулж, үр дүнгийн урамшуулал олгох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөл баталснаар эмнэлгийн захиралд олгосон байна.

- **ЭМД-ын хөнгөлөлттэй эмийн асуудлын хүрээнд орсон өөрчлөлт:**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дэх заалтад өөрчлөлт оруулж, ЭМДС-аас олгох хөнгөлөлттэй эмийн жорыг зөвхөн өрх, сумын Эрүүл мэндийн төвийн эмч нар бичиж ирсэн хязгаарлалтыг өөрчилж, лавлагаа шатлалын эмч нар мөн адил хөнгөлөлттэй эмийн жор бичдэг болсон, ЭМБ-ын эмчийн бичсэн жороор эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон ерөнхий нэршлийн эмийг тухайн эрүүл мэндийн байгууллагын эмийн сан, бусад эмийн сангаас хөнгөлөлттэй үнээр худалдах боломжтой болсон, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эмийн сангууд сонгон шалгаруулалтгүйгээр ЭМД-ын байгууллагатай гэрээ байгуулж, хөнгөлөлттэй эмээр үйлчлэх боломжтой болсон байна.

A1.3.Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог үр дүнтэй зохион байгуулж ажилласан байна

Эрүүл мэндийн багц хуулиудын өөрчлөлтөөр хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн чанартай тусламж, үйлчилгээг сангийн эх үүсвэртээ тохируулан худалдан авах буюу стратегийн худалдан авалтын тогтолцоонд шилжсэнээр байгаа нөөцөө ухаалаг зарцуулах, иргэдэд чанартай тусламж, үйлчилгээг үзүүлэх эхлэл тавигдсан байна.

Улсын төсвийн санхүүжилтийг ЭМД-ын санд шилжүүлснээр тусламж, үйлчилгээг иргэн, даатгуулагчид чанартай үзүүлсэн тохиолдолд санхүүжилт олгохоор болсон бөгөөд, үүнээс үүдэлтэй ЭМБ-ууд хооронд өрсөлдөөн бий болох боломж бүрдсэн байна.

Хууль тогтоомжуудад орсон өөрчлөлтийн хүрээнд ЭМДҮЗ-ээс эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцоог үр дүнтэй зохион байгуулах, сангийн үр ашгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд ЭМДҮЗ-ээс 2021 онд “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга батлах тухай” 3 дугаар тогтоол, “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 4 дүгээр тогтоол, “Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний үлгэрчилсэн загвар шинэчлэн батлах тухай” 13 дугаар тогтоол, 2021 оны “Хяналтын журам батлах тухай” 5 дугаар тогтоол, 2022 онд “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 01 дүгээр тогтоол, “Чанар, төлбөрийн хяналтын журам” 12 дугаар тогтоол, “Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоолуудыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

ЭМДҮЗ-ийн 2021 оны “Хяналтын журам батлах тухай” 5 дугаар тогтоол, 2022 оны “Чанар, төлбөрийн хяналтын журам” 12 дугаар тогтоол гарснаар нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэх аргачлал, шалгууртай болж цахимаар хянадаг боломж бүрдэж, 2023 оноос эхлэн эмнэлгүүдийн өвчний түүхийг цахимаар хянуулахаар болсон байна.

Эрүүл мэндийн байгууллагуудад олгох санхүүжилтийг гүйцэтгэлээр буюу тохиолдолд суурилсан аргаар санхүүжүүлэх болсонтой холбогдуулан байгууллагын нөөцүүдийг (санхүү, хүний, тоног төхөөрөмжийн болон барилга байгууламжийн) оновчтой удирдах, үр ашгийг дээшлүүлэх асуудал зайлшгүй тавигдах болсонтой холбогдуулан аймгийн Нэгдсэн эмнэлгүүдэд Төлөөлөн удирдах зөвлөл байгуулж ажиллуулах талаар холбогдох хуулиудад өөрчлөлт орсон байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10-д заасны дагуу ТУЗ нь эмнэлгийн төсвийг орлогын чадамжид үндэслэн батлах, эмнэлгийн гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг сайжруулах зорилго бүхий гэрээнд үндэслэж томилох, чөлөөлөх, орон тоо, бүтцийг тогтоох, шийдвэрлэх, цалингийн сан, урамшууллын журмыг тогтоох эрхтэй гэж заасан байна. Мөн хуульд төсвийн хуваарийг ТУЗ-өөр батлуулж, гүйцэтгэх захирал хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хүний нөөц, цалин урамшууллын шийдвэрийг СЯ-аас баталсан орон тоо, цалингийн сан, Төрийн албан хаагчийн цалин, урамшууллын тогтоол, журмаар хязгаарлагддаг байсан бол ТУЗ байгуулж ажилласнаар байгууллагын бүтэц, орон тоо, дүрэм, чиг үүрэг, цалингийн санг тогтоох эрхийг ТУЗ-д өгсөн байна. Өөрөөр

хэлбэл байгууллагын оновчтой бүтцийг байгууллага өөрөө баталж, хэрэгжүүлэх боломжийг бүрүүлж өгсөн байна.

ТУЗ-тэй эмнэлгүүдийн хувьд цалингийн сандаа багтааж бүтээмжийн урамшууллыг гүйцэтгэх захирлын шийдвэрээр олгох боломжтой болсон байна. Эмнэлгийн ажилчид нь төрийн албан хаагч бөгөөд Төрийн албаны тухай хууль, түүнийг дагаж гарсан Засгийн газрын тогтоол шийдвэрүүдийн дагуу нэмэгдэл, урамшуулал авдаг бөгөөд үүнд нэмэлтээр эмнэлгийн гүйцэтгэлийг сайжруулсны төлөө “бүтээмжийн урамшууллыг” авах хууль эрх зүйн боломж нээгдсэн байна.

Нэгдсэн эмнэлэг нь эмнэлгийн нөөцийн үр ашгийг сайжруулах, сул зогсолт ихтэй байгаа хэсгүүдийг эргэлтэд оруулах (хүн нөөц, өрөө, тоног төхөөрөмж), эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох талаар анхаарч ажиллах шаардлагатай тул Төлөөлөн удирдах зөвлөл байгуулж ажиллах нь зүйтэй байна.

Мөн түүнчлэн эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийн нэг нь хувийн эмнэлэг, улсын эмнэлэгт олгох ОХБ-ийн суурь тарифын ялгааг ижил болгож, улсын болон хувийн эмнэлгүүд ижил тарифаар тусламж, үйлчилгээ үзүүлж, иргэнээс хамтын төлбөрөөс өөр хэлбэрээр төлбөр төлүүлэхийг хориглосон байна.

Б.Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үр нөлөө бага байна

Б.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн боловч эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна

Б1.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн байна

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр тусгасан байна. Үүнд:

19.1.1 (Даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл), 19.1.2 (ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл), 19.1.3 (төр даатгалыг нь хариуцах иргэдэд улсын төсвөөс төлсөн шимтгэл), 19.1.5 (төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгох хөрөнгө), 19.1.6 (сангийн чөлөөт үлдэгдлийн хүү), 19.1.7 (эрсдэлийн нөөцийг хадгалуулсны хүү), 19.1.8 (эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд ногдуулсан алданги), 19.1.9 (бусад эх үүсвэр).

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын дэвшүүлсэн стратегийн зорилтод: “Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, төлбөр тооцоо гүйцэтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, гүйцэтгэлийг тайлагнах” гэж тусгасан байдаг.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021, 2022 оны төсвийн тухай хууль, ЭМДҮЗ-ийн төсвийн хуваарийг батлах тухай тогтоолуудыг үндэслэн ЭМДЕГ-ын даргын 2021 оны “Төсвийн орлогын сар, улирлын хуваарь батлах тухай” А/.. тушаал, 2022 оны “Төсвийн орлогын сар, улирлын хуваарь батлах тухай” А/14 тушаалаар

ЭМД-ын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 2021 онд 4,229.0 сая төгрөгөөр, 2022 онд 10,511.2 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт №01 ЭМДС-ын орлогын 2021-2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөг)


Даатгуулагчийн төрөл	огноо	Төлөвлөгөө	Биелэлт	Зөрүү	хувь
АО, даатгуулагчийн төлөх шимтгэл /ЭМД тухай хуулийн 6.1.1/	2021	3,790.7	4,990.6	(1,199.9)	131.7
	2022	9,626.0	5,981.3	3,644.7	62.1
Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, суралцагсдын шимтгэл	2021	434.5	312.1	122.4	71.8
	2022	885.2	533.3	351.9	60.2
Бусад орлого	2021	3.8	3.2	0.6	84.2
	2022	-	4.6	(4.6)	
ЭМД-ын шимтгэлийн нийт орлого	2021	4,229.0	5,305.9	(1,076.9)	125.5
	2022	10,511.2	6,519.2	3,992.0	62.0

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн НДХ-ийн 2021-2022 оны тайлан

ЭМД-ын санд 2021 онд нийт дүнгээр 4,229.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 5,305.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 1,076.9 сая төгрөгөөр буюу 25.5 хувиар давуулан биелүүлсэн байна. Үүнээс ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлогоос 3,790.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 4,990.0 сая төгрөг төвлөрүүлж 1,199.9 сая төгрөгөөр буюу 31.7 хувиар давуулан биелүүлж, шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлогоос 434.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 312.1 сая төгрөгийг төвлөрүүлж 122.4 сая төгрөгөөр дутуу буюу 28.2 хувиар тасарсан байна.

2022 онд нийт дүнгээр 10,511.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 6,519.2 сая төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 3992.0 сая төгрөгөөр буюу 38 хувиар тасарсан байна. Үүнээс ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого 9,626.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 5,981.3 сая төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөө 3,644.7 сая төгрөгөөр дутуу буюу 37.9 хувиар, шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлого 885.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 533.3 сая төгрөгийг төвлөрүүлж 351.9 сая төгрөгөөр дутуу буюу 39.8 хувиар тасарчээ.

График №01 ЭМДШ-ийн 2021,2022 оны орлогын төлөвлөгөөний биелэлт



ЭМД-ын хамралтын тайлангаар¹ төсөвт болон аж ахуйн нэгжийн ажилтны тоо 2021 онд 14246 байсан бол 2022 онд 15064 болж 818 даатгуулагчаар нэмэгдсэн байна.

Аймгийн Статистикийн хэлтсийн 2022 оны судалгаагаар² аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын сарын дундаж цалин 1.07 сая төгрөг, тайлант онд нэмэгдсэн 818 даатгуулагчийн цалингийн санг жилээр тооцвол 10,503.1 сая төгрөг ба үүнд ногдох ЭМД-ийн шимтгэл нь 420.1 сая төгрөг байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт орлогын 2021 онд 94 хувийг, 2022 онд 91.7 хувийг ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл эзэлж байна. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 2022 онд өмнөх оноос 6,282.2 сая төгрөгөөр буюу 2.4 дахин нэмэгдүүлж төлөвлөсөн боловч 62 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Үүнээс үзэхэд Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө үндэслэлгүй өндөр төлөвлөгдсөн байна.

Зарлагын хувьд Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлгийг 2021 онд 8,812.6 сая төгрөгөөр, 2022 онд 12,050.8 сая төгрөгөөр баталж, эмнэлгүүдэд олгох санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр баталсан байна.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төвлөрүүлэлтийн талаар:

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2021 онд ажил олгогч, даатгуулагчаас төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалт болон төлбөрийн акт, алданги, харилцах дансны хүүгээс нийтдээ 4,933.8 сая төгрөгийн, 2022 онд 5,981.6 сая төгрөгийн орлого төвлөрснийг ЭМДЕГ-т бүрэн төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №02: 2021-2022 оны ЭМДШ-ын төвлөрүүлэлт

(сая төгрөг)

огноо	Нийт орлогын дүн	Хуулийн 6.1.1 дэх заалтын даатгуулагч	бусад орлого		
		А.о, даатгуулагчийн төлсөн шимтгэл	акт	алданги	харилцах дансны хүү
2021 он	4,933.8	4,990.6	1.7	0.9	0.6
2022 он	5,986.2	5,981.6	2.9	1.4	0.3

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн НДХ-ийн 2021-2022 оны тайлан

Тус хэлтсээс шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэдийн төлсөн 2021 онд 312.1 сая төгрөгийн, 2022 онд 533.3 сая төгрөгийн ЭМДШ-ийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.

¹ БӨ аймгийн НДХ-ийн 2021-2022 оны тайлан

² Аймгийн Статистикийн хэлтсээс ирүүлсэн судалгаа

Хүснэгт №03: Шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэдийн 2021-2022 оны ЭМДШ-ын төвлөрүүлэлт (сая төгрөг)

ОГНОО	Шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэд /хуулийн 6.1.2-4, 6.1.9 дэх заалтын даатгуулагч/					
	Нийт орлогын дүн	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	малчдын төлсөн шимтгэл	Оюутан, суралцагчдын төлсөн шимтгэл	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн	бусад даатгуулагчийн төлсөн шимтгэл
2021 он	312.1	29.0	88.8	38.9	1.9	153.5
2022 он	533.3	61.5	139.0	66.5	4.0	262.3

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн НДХ-ийн 2021-2022 оны тайлан

Б1.2.Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж, гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна

Эрүүл мэндийн багц хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтөөр эмнэлгүүдэд улсын төсвөөс олгож байсан санхүүжилтийн эх үүсвэрээ ЭМДС-д нэгтгэж, тохиолдолд суурилсан аргаар санхүүжүүлэхээр болж, ЭМДЕГ нь эрүүл мэндийн байгууллагуудаас чанартай тусламж, үйлчилгээг худалдан авч, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахаар болсон байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7-т “даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах” гэж заасныг үндэслэн ЭМДҮЗ-өөс 2021 онд “Хяналтын журам батлах тухай” 05 дугаар тогтоолыг баталж, 2022 оны 12 дугаар тогтоолоор “Чанар, төлбөрийн хяналтын журам” гаргаж шинэчлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс 2021 онд гэрээ байгуулсан улсын эмнэлэг 2, хувийн эмнэлэг 6, сувилал 1, Өрхийн ЭМТөв 4, Сумын ЭМТөв 13, эмийн сан 49, нийт **75** байгууллагын, 2022 онд улсын эмнэлэг 1, хувийн эмнэлэг 6, Өрхийн ЭМТөв 4, Сумын ЭМТөв 14, эмийн сан 42, нийт **67** эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн нэхэмжлэлийг хүлээн авч, хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт:№04 ЭМБ-ын 2021-2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал (сая төгрөг)

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	огноо	ЭМБ тоо	Нэхэмжилсэн		Эмч, байцаагч болон системийн хасалт		Олговол зохих санхүүжилт	
				Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн
1	Улсын эмнэлгийн дүн	2021	2	212,719	16,051.7	27,890	3,415.9	184,829	12,635.8
		2022	1	187,107	15,020.5	10,336	2,213.2	176,771	12,807.3
2	Хувийн эмнэлгийн дүн	2021	6	49,334	5,151.7	849	240.5	48,485	4,911.1
		2022	6	31,566	5,080.6	2,394	427.9	29,172	4,652.7
3	Сувиллын дүн	2021	1	925	231.2	65	16.2	860	215.0
		2022	0	-	-	-	-	-	-

4	Өрхийн ЭМТ-ийн дүн	2021	4	74,794	1,316.7	6,480	243.6	68,292	1,073.1
		2022	4	38,410	2,157.8	950	58.9	37,460	2,098.8
5	Сумын ЭМТөвийн дүн	2021	13	101,486	2,152.2	4,119	331.7	97,367	1,820.5
		2022	14	135,265	10,850.2	2,995	133.1	132,270	10,717.2
6	Эмийн сан	2021	49	76,715	3,882.4	2,114	89.4	74,628	3,792.9
		2022	42	41,204	2,054.8	1,615	64.2	39,589	1,990.6
Дүн		2021	75	515,973	28,785.9	41,517	4,337.3	474,461	24,448.4
Дүн		2022	67	433,552	35,163.9	18,290	2,897.3	415,262	32,266.6

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЭМДХэлтсийн 2021-2022 оны тайлан

Тайлбар: Цэнгэл сумын ЭМТөв 2021 онд сум дундын эмнэлгийн статустай байсан тул улсын эмнэлгийн тоонд орсон байна.

Эрүүл мэндийн байгууллагуудыг тохиолдолд суурилсан аргаар санхүүжүүлэхтэй холбогдуулан 2021 онд нийтдээ 515,973 даатгуулагчид үзүүлсэн 28,785.9 сая төгрөгийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилснээс эмч, байцаагчийн болон системийн хасалтаар 41,517 даатгуулагчид үзүүлсэн 4,337.3 сая төгрөгийн нэхэмжлэлд хасалт хийгдэж, 474,461 даатгуулагчид 24,448.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцоо нийлсэн байна.

2022 онд нийт 433,552 даатгуулагчид үзүүлсэн 35,163.9 сая төгрөгийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилснээс 18,290 даатгуулагчид үзүүлсэн 2,897.3 сая төгрөгийн нэхэмжлэлд хасалт хийгдэж 415,262 даатгуулагчид 32,266.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон байна.

Эмч, байцаагчийн болон системийн хяналтаар 2021 онд нэхэмжилсэн хүний тоотой харьцуулахад 8 хувийн, мөнгөн дүнтэй харьцуулахад 15 хувийн буюу 4,337.3 сая төгрөгийн, 2022 онд нэхэмжилсэн хүний тоотой харьцуулахад 4.2 хувийн, мөнгөн дүнтэй харьцуулахад 8.2 хувийн буюу 2,897.3 сая төгрөгийг нэхэмжлэлийн дүнгээс хасалт хийсэн байна.

Аймгийн ЭМДХ-ийн нэхэмжлэлийн хяналтаар 2021 онд нийт 75 эрүүл мэндийн байгууллагад тооцоо нийлж, гүйцэтгэлээр 24,448.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 21,063.4 сая төгрөгийн санхүүжилт, 2022 онд нийт 67 эрүүл мэндийн байгууллагад 32,266.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 35,681.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт: №05 ЭМБ-уудад 2021-2022 онд олгосон санхүүжилт (сая төгрөг)

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	огноо	ЭМБ тоо	эхний үлдэгдэл		Олговол зохих санхүүжилт	Олгосон санхүүжилт	эцсийн үлдэгдэл	
				авлага	өглөг			авлага	өглөг
1	Улсын эмнэлгийн дүн	2021	2			12,650.7	10,394.5		2,256.2
		2022	1	3.7	2,256.2	12,807.3	15,059.8		
2	Хувийн эмнэлгийн дүн	2021	6			4,911.1	4,480.3		430.8
		2022	6		430.8	4,652.7	5,083.5		
3	Сувилахын дүн	2021	1			215.0	215.0		

		2022	0			-	0.8	0.8	
4	Өрхийн эмнэлгийн дүн	2021	4			1,073.1	1,067.7	37.5	42.8
		2022	4	60.3	65.7	2,098.8	2,104.2	-	-
5	Сумын ЭМТөвийн дүн	2021	13			2,396.4	1,937.4	0.4	459.5
		2022	14	24.6	487.4	10,717.2	11,208.9	29.0	0.06
6	Эмийн сан	2021	49			3,202.1	2,968.5		233.6
		2022	42		233.6	1,990.6	2,224.2		
	Дүн	2021	75	-	-	24,448.4	21,063.4	37.9	3,422.9
	Дүн	2022	67	88.6	3,473.7	32,266.6	35,681.4	29.8	0.06

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЭМДХ-ийн 2021-2022 оны тайлан

Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2021 онд 37.5 сая төгрөгийн, сумын Эрүүл мэндийн төвүүдэд 0.4 сая төгрөгийн, нийт 37.9 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон бол, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2,256.2 сая төгрөгийн, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд 430.8 сая төгрөгийн, өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд 42.8 сая төгрөгийн, сумын Эрүүл мэндийн төвүүдэд 459.5 сая төгрөгийн, эмийн сангуудад 233.6 сая төгрөгийн, нийт 3,422.9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Эрүүл мэндийн байгууллагуудад 2021 оны гүйцэтгэлийн санхүүжилтийг дутуу олгосон нь Ковид-19 цар тахлын өвчний дэгдэлт улс даяар тархаж, санхүүжилтийн эх үүсвэр дутсантай холбоотой байна.

Харин 2022 онд өмнөх оны санхүүжилтийн дутууг бүрэн олгож, Өлгий сумын Хотгор багийн Эрүүл мэндийн төвд 29.0 сая төгрөг, “Ахсу” рашаан сувилалд 0.8 сая төгрөг, нийт 29.0 сая төгрөгийн санхүүжилтийн авлагатай гарсан байна.

Иргэн, даатгуулагчид лавлагаа шатлалын тусламж үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний гүйцэтгэл:

Нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнтэй холбогдуулан ЭМДҮЗ-ийн 2021 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 03 тогтоолоор 562 ОХБ-ийн жагсаалт, төлбөрийн хэмжээг баталсан бол зарим оношны хамааралтай бүлгийн давхардлыг арилгах зорилгоор ЭМДҮЗ-ийн 2022 оны “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 01 дүгээр тогтоолоор 705 ОХБ-ийн жагсаалт, төлбөрийн хэмжээг баталж өөрчлөлт оруулан, эрүүл мэндийн даатгалын цахим программд өөрчлөлт, хөгжүүлэлт хийгдсэн байна.

Лавлагаа шатны ЭМБ-ын эрүүл мэндийн байгууллагуудыг гүйцэтгэлээр санхүүжүүлэхтэй холбогдуулан 2021 онд 9 байгууллага 179,563 тохиолдлын 14,607.9 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс эмч, байцаагч болон системийн хяналтаар 27,463 тохиолдлын 2,745.4 сая төгрөгийн санхүүжилт хасагдсан бөгөөд нэхэмжилсэн хүний тоотой харьцуулахад 15.2 хувь, мөнгөн дүнтэй харьцуулахад 18.7 хувийг эзэлж байна.

2022 онд 7 байгууллага 182,257 тохиолдлын 18,120.6 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс эмч, байцаагч болон системийн хяналтаар 9,912 тохиолдлын 2,246.2 сая төгрөгийн санхүүжилт хасагдсан бөгөөд нэхэмжилсэн хүний тоотой харьцуулахад 5.4 хувь, мөнгөн дүнтэй харьцуулахад 12.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт:№06 Лавлагаа шатны ЭМБ-ын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал (сая төгрөг)

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	огноо	ЭМБ тоо	Нэхэмжилсэн		Эмч, байцаагч болон системийн хасалт		Олговол зохих санхүүжилт	
				Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн
1	Улсын эмнэлгийн дүн	2021	2	170829	10,151.8	27219	2,544.7	143610	7,607.1
		2022	1	171004	13,473.7	9494	1,926.9	161510	11,546.8
2	Хувийн эмнэлгийн дүн	2021	6	7809	4,224.9	179	184.4	7630	4,040.5
		2022	6	11253	4,646.9	418	319.3	10835	4,327.6
3	Сувиллын дүн	2021	1	925	231.2	65	16.3	860	214.9
		2022	0	-	-	-	-	-	-
Дүн		2021	9	179563	14,607.9	27463	2,745.4	152100	11,862.5
Дүн		2022	7	182257	18,120.6	9912	2,246.2	172345	15,874.4

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЭМДХ-ийн 2021-2022 оны тайлан

Нэхэмжлэлийн хяналтаар 2021 онд 2 улсын эмнэлгээс (Нэгдсэн эмнэлэг, Цэнгэл сумын СДЭ) цахим болон эмч, байцаагчийн хасалтаар 27219 хүний 2,544.7 сая төгрөгийн нэхэмжлэл хасагдсан нь нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 25 хувь, тохиолдлын тоотой харьцуулахад 16 хувийг эзэлж байна.

Харин 2022 онд 9494 хүний 1926.9 сая төгрөгийн нэхэмжлэлийн хасагдалт хийгдсэн нь нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 14.3 хувь, тохиолдлын тоотой харьцуулахад 5.5 хувийг эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулахад нэхэмжлэлийн мөнгөн дүнгийн хасагдалт 617.8 сая төгрөгөөр багассан нь аймгийн ЭМДХ-ээс зөрчил арилгах талаар арга хэмжээ авч ажилласантай холбоотой байна.

Хувийн хэвшлийн 6 эмнэлгээс 2021 онд цахим болон эмч, байцаагчийн хяналтаар 179 хүний 184.4 сая төгрөгийн нэхэмжлэлийн хасагдалт хийгдсэн нь нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 2.3 хувь тохиолдлын тоотой харьцуулахад 4.3 хувийг, 2022 онд 418 хүний 319.3 сая төгрөгийн нэхэмжлэлийн хасагдалт хийгдсэн нь нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 3.7 хувь, тохиолдлын тоотой харьцуулахад 6.8 хувийг тус тус эзэлж байна.

“Ах-су” рашаан сувиллаас 2021 онд 925 тохиолдлын 231.2 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс цахим болон эмч, байцаагчийн хяналтаар 65 хүний 16.3 сая төгрөгийн нэхэмжлэлийн хасагдалт хийгдсэн бөгөөд 2022 онд ЭМЯ-аас магадлан итгэмжлэлийн сунгалтын шийдвэр нь хожуу гарсантай холбоотой ЭМДС-аас санхүүжилт авах боломжгүй болсон байна.

Лавлагаа шатлалын ЭМБ-ын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэхэмжлэлийн хасалт нь программын дутуу хөгжүүлэлт, маягт дутуу бөглөх, оношны үндэслэл дутуу бичигдсэн, шаардлагатай тоног төхөөрөмжийн дутмагаас оношилгоо, шинжилгээ дутуу хийгдсэн, эмч, мэргэжилтний мэдлэг, чадвар дутмаг зэрэг зөрчлүүдээс шалтгаалдаг байна.

Иргэн, даатгуулагчид анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэл:

Сумдын Эрүүл мэндийн төвүүдээс иргэн, даатгуулагчид үзүүлж буй зарим сэргээн засах, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх, оношилгоо, шинжилгээ гэсэн 4 төрлийн үйлчилгээний тарифыг ЭМДҮЗ-ийн 2019 оны “Журам, жагсаалт, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тогтоолоор, нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээ, тохиолдолд суурилсан буюу хэвтүүлэн эмчлэх, шүд, түргэн тусламж болон яаралтай тусламжийн үйлчилгээний тарифыг ЭМДҮЗ-ийн 2021 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 04 дүгээр тогтоолоор баталж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийг олгож ирсэн байна.

Дээрх журмуудыг ЭМДҮЗ-ийн 2022 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолоор дахин шинэчлэн баталсан бөгөөд уг тогтоолоор нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээг 2 дахин нэмж, хэвтүүлэн эмчлэх, шүд, түргэн тусламж болон яаралтай тусламжийн үйлчилгээг лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх багц, төлбөрийн аргаар олгохоор, зарим сэргээн засах, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх, оношилгоо, шинжилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээний багцыг нэмж шинэчилсэн байна.

Хүснэгт:№07. Анхан шатны ЭМБ-ын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал (сая төгрөг)

ЭМБ-ын төрөл	Тусламж, үйлчилгээний төрөл	огноо	ЭМБ тоо	Нэхэмжилсэн		Эмч, байцаагч болон системийн хасалт		Олговол зохих санхүүжилт	
				Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн
Өрхийн ЭМТөв	Өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх, сэргээн засах, оношилгоо, шинжилгээ	2021	4	3,934	136.2	138	3.8	3,796	132.4
		2022	4	4,231	191.7	781	31.9	3,450	159.8
Сумын ЭМТөв	Оношилгоо, шинжилгээ	2021	13	7,692	337.6	997	42.9	6,695	294.7
		2022	13	7,687	353.5	2,434	94.9	5,253	258.6
Өрхийн ЭМТөв	Нэг иргэнээр тооцсон	2021	0	-	-	0	0	-	-
		2022	4	29402	1,764.2			29402	1,764.2
Сумын ЭМТөв	Төлбөрийн хэмжээ	2021	0						
		2022	4	110254	6,615.3			110254	6,615.3
Сумын ЭМТөв	Хэвтүүлэн, шүд, түргэн тусламж, яаралтай	2021	0	-	-	-	-	-	-
		2022	14	1852	3,560.8	4350	173.5	1,852	3,560.8

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЭМДХ-ийн 2021-2022 оны тайлан

Өрхийн болон сумын Эрүүл мэндийн төвүүдэд олгосон нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг 2021 онд улсын төсвөөс олгосон бөгөөд 2022 онд Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 1,764.2 сая төгрөгийн, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд 6,615.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Сум, тосгоны Эрүүл мэндийн төвүүдэд 2022 онд тохиолдолд суурилсан лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх багц, төлбөрийн аргаар тооцож 3,560.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 2022 оны 03 дугаар сараас эхлэн нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж анхан шатны тусламж үйлчилгээ (өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх, сэргээн засах, оношилгоо, шинжилгээ) болон нэг иргэнээр тооцсон 3-аас 10 дугаар саруудын санхүүжилтийг статистик тоо мэдээлэлд

үндэслэн бүрэн олгосон байна. Харин 11-12 дугаар сараас эхлэн программд бүрэн шилжиж гүйцэтгэлээр олгож эхэлсэн байна.

Өрхийн Эрүүл мэндийн төвүүдээс 2021 онд зарим сэргээн засах, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх, оношилгоо, шинжилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээний 3934 тохиолдлын 136.2 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс цахим болон эмч, байцаагчийн хяналтаар 138 хүний 3.8 сая төгрөгийн хасагдалт хийгдэж, нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 2.8 хувь, тохиолдлын тоотой харьцуулахад 3.5 хувийг, 2022 онд 4231 тохиолдлын 191.7 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс 781 хүний 31.9 сая төгрөгийн хасагдалт хийгдсэн нь нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 16.6 хувь тохиолдлын тоотой харьцуулахад 18.4 хувийг тус тус эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулахад тохиолдлын тоо 643, мөнгөн дүн 28.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж, гүйцэтгэлийн хяналтыг бодитой хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой байна.

Сумын Эрүүл мэндийн төвүүдээс 2021 онд 7692 тохиолдлын 337.6 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс цахим болон эмч, байцаагчийн хяналтаар 997 тохиолдлын 42.9 сая төгрөгийн нэхэмжлэлийн хасагдалт хийгдэж, нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 12.7 хувь, тохиолдлын тоотой харьцуулахад 12.9 хувийг, 2022 онд 7687 тохиолдлын 353.5 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилснээс цахим болон эмч, байцаагчийн хяналтаар 2434 тохиолдлын 94.9 сая төгрөгийн нэхэмжлэлийн хасагдалт хийгдэж, нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 26.8 хувь, тохиолдлын тоотой харьцуулахад 31.6 хувийг эзэлж байна.

Өмнөх онтой харьцуулахад тохиолдлын тоо 1437, мөнгөн дүн 52.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь мөн адил нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж, гүйцэтгэлийн хяналтыг бодитой хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотой байна.

ЭМДС-аас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмээр үйлчилсэн гэрээт эмийн сангуудын гүйцэтгэл:

ЭМДҮЗ-ийн 2020 оны “Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 13 дугаар тогтоолоор ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г баталж, ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 тогтоолоор шинэчлэн баталсан байна.

ЭМДҮЗ-д 2021 онд гэрээ байгуулсан нийт 49 эмийн сан 76,012 хүний 3840.7 сая төгрөгийн хөнгөлөлттэй эмийн зардлыг нэхэмжилснээс эмч, байцаагч, системийн хяналтаар 2,110 тохиолдлын 83.6 сая төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлтийн зардал хасагдсан нь нэхэмжилсэн хүний тоотой харьцуулахад 2.7 хувь, мөнгөн дүнтэй харьцуулахад 2.1 хувийг эзэлж байна.

2022 онд гэрээ байгуулсан нийт 54 эмийн сан 47,546 хүний 2,252.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй эмийн зардлыг нэхэмжилснээс эмч, байцаагч, системийн хасалтаар 2,107 тохиолдлын 79.7 сая төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлтийн зардал хасагдаж, нэхэмжилсэн хүний тоотой харьцуулахад 4.4 хувь, мөнгөн дүнтэй харьцуулахад 3.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт:№8. Эмийн үнийн хөнгөлөлт олгох тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал
(сая төгрөг)

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	огноо	ЭМБ тоо	Нэхэмжилсэн		Хасагдсан		Олговол зохих санхүүжилт	
				Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн
1	Хувийн эмийн сангийн дүн	2021	36	60,771	3,216.0	1,327	48.4	59,444	3,167.6
		2022	42	40,627	2,033.2	1,615	64.2	39,012	1,968.9
2	Сумын эмийн сангууд	2021	13	15,241	624.7	783	35.2	14,485	589.5
		2022	12	6,919	219.4	492	15.5	6,427	203.8
Дүн		2021	49	76,012	3,840.7	2,110	83.6	73,929	3,757.1
Дүн		2022	54	47,546	2,252.6	2,107	79.7	45,439	2,172.7

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЭМДХ-ийн 2021-2022 оны тайлан

Хувийн эмийн сангуудаас 2021 онд цахим болон эмч, байцаагчийн хяналтаар 1327 хүний 48.4 сая төгрөгийн нэхэмжлэлийн хасагдалт хийгдэж, нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 2.1 хувь, тохиолдлын тоотой харьцуулахад 1.5 хувийг, 2022 онд 1615 хүний 64.2 сая төгрөгийн нэхэмжлэлийн хасагдалт хийгдэж, нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 3.1 хувь, тохиолдлын тоотой харьцуулахад 3.9 хувийг эзэлж байна.

Сумдын эмийн сангуудаас 2021 онд цахим болон эмч, байцаагчийн хяналтаар 783 хүний 35.2 сая төгрөгийн нэхэмжлэлийн хасагдалт хийгдэж, нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 5.6 хувь, тохиолдлын тоотой харьцуулахад 5.1 хувийг, 2022 онд 492 хүний 15.5 сая төгрөгийн нэхэмжлэлийн хасагдалт хийгдэж, нэхэмжилсэн мөнгөн дүнтэй харьцуулахад 7.0 хувь, тохиолдлын тоотой харьцуулахад 7.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт: №09 Вируст гепатит В,С вирусын эмийн олголт (сая төгрөг)

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	огноо	ЭМБ тоо	Нэхэмжилсэн		Хасагдсан		Олговол зохих санхүүжилт	
				Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн
1	Хувийн эмийн сангийн дүн	2021	21	651	40.2	2	5.7	649	34.5
		2022	15	589	21.9	-	-	589	21.9
2	Сумын эмийн сангууд	2021	4	52	1.4	2	0.1	50	1.3
		2022	0	-	-	-	-	-	-
	Дүн	2021	25	703	41.6	4	5.8	699	35.8
	Дүн	2022	15	589	21.9	-	-	589	21.9

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЭМДХ-ийн 2021-2022 оны тайлан

“Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд олгогдох вируст гепатит В,С вирусын эмийн олголтын хувьд хувийн эмийн сангуудаас 2021 онд 2 хүний 5.7 сая төгрөгийн эмийн зардал, сумын эмийн сангуудаас 2 хүний 0.1 сая төгрөгийн эмийн зардал хяналтаар хасагдсан байна.

Даатгуулагчийг урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний гүйцэтгэл:

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдсан даатгуулагчдад олгох санхүүжилтийг ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг санхүүжүүлэх журам”, “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц, төлбөрийн хэмжээ”, ЭМДЕГ-ын даргын 2022

оны А/39 тоот тушаалаар баталсан “Нэхэмжлэлийг хянах журам”-ын 8.2.4-т заасныг үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний гүйцэтгэлд чанарын хяналт хийж хэрэгжүүлсэн байна.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг лавлагаа шатны эмнэлгүүдээс Нэгдсэн эмнэлэг, “Жаншарапат”, “Нурлы”, “Фатиха” зэрэг 4 эмнэлэг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас “Жансая”, “Шипагер” өрхийн эрүүл мэндийн төвүүд гэрээгээр гүйцэтгэсэн байна.

Хүснэгт:№10 Урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал (сая төгрөг)

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	огноо	ЭМБ тоо	Нэхэмжилсэн		Хасагдсан		Олговол зохих санхүүжилт	
				Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн
1	Нэгдсэн эмнэлгийн дүн	2021	1	18,914	217.5			18,914	217.5
		2022	1	8,852	369.4	804	151.5	8,048	217.9
2	Хувийн эмнэлгийн дүн	2021	3	41,148	453.5	611	6.3	40,537	447.2
		2022	3	20,313	433.7	1,976	108.6	18,337	325.1
3	Өрхийн эмнэлгийн дүн	2021	2	367	3.7	11	0.1	356	3.6
		2022	1	134	1.3	-	-	134	1.4
Дүн		2021	6	60,429	674.7	622	6.4	59,807	668.3
Дүн		2022	5	29,299	804.4	2,780	260.1	26,519	544.4

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЭМДХ-ийн 2021-2022 оны тайлан

Урьдчилсан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ тусламж, үйлчилгээний хувьд 2021 онд нийт 6 эрүүл мэндийн байгууллага 60,429 даатгуулагчид үзүүлсэн 674.7 сая төгрөгийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилснээс эмч, байцаагчийн болон системийн хяналтаар 622 даатгуулагчид үзүүлсэн 6.4 сая төгрөгийн нэхэмжлэлд хасалт хийгдэж /нэхэмжилсэн хүний тоотой харьцуулахад 1.0 хувь, мөнгөн дүнтэй харьцуулахад 0.9 хувь/, 59,807 даатгуулагчид 668.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон.

2022 онд 29,299 даатгуулагчид үзүүлсэн 804.4 сая төгрөгийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилснээс 2780 даатгуулагчид үзүүлсэн 260.1 сая төгрөгийн нэхэмжлэлд хасалт хийгдэж /нэхэмжилсэн хүний тоотой харьцуулахад 9.4 хувь, мөнгөн дүнтэй харьцуулахад 32.3 хувь/, 26519 даатгуулагчид 544.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон байна.

Коронавируст халдварын үеийн тусламж үйлчилгээний гүйцэтгэл:

Коронавируст халдварын үеийн тусламж үйлчилгээний нэхэмжлэлийг ЭМС, СС-ын “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай” 2021 оны 67/А/268 болон А/387/99 дугаар хамтарсан тушаал, ЭМС-ын “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай” 2021 оны А/140, А/318, А/467, А/549 дугаар тушаал, бусад холбогдох тушаал, журам, зааврын дагуу нэхэмжлэлийг хянаж ажилласан байна.

Хүснэгт:№11 Коронавируст халдварын үеийн тусламж үйлчилгээний зардал нэхэмжилсэн байдал. (сая төгрөг)

№		огноо	Нэхэмжилсэн	Хасагдсан	Олговол зохих санхүүжилт
---	--	-------	-------------	-----------	--------------------------

	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	Ковид-19 цар тахал		ЭМ Б тоо	Хүн	мөнгөн дүн	Хүн	мөнгөн дүн	хүн	мөнгөн дүн
1	Улсын эмнэлгийн дүн	хэвтэн	2021	1	2422	5,130.6	401	868.2	2021	4,262.5
			2022	1	437	990.0	34	134.6	403	855.4
2	Сувиллын дүн	хэвтэн	2021	1	377	473.2	59	49.8	318	423.4
			2022	0	-	-	-	-	-	-
3	Сумын ЭМТ-ийн дүн	хэвтэн	2021	13	1068	1,043.3	145	141.8	923	901.4
			2022	13	42	41.2	14	13.7	28	27.4
1	Өрхийн ЭМТөв	Ковид-19 өрх	2021	4	5337	851.2	1217	214.1	4120	637.1
			2022	4	1144	183.1	169	27.1	975	156.0
2	Сумын ЭМТ-ийн дүн	Ковид-19 өрх	2021	13	1886	302.4	784	131.3	1102	171.2
			2022	8	111	17.7	55	8.8	56	8.9
1	Өрхийн ЭМТөв	Ковид-вакцин	2021	4	65093	325.5	5114	25.6	59979	299.9
			2022	4	3499	17.5	0	-	3499	17.5
2	Сумын ЭМТ-ийн дүн	Ковид-вакцин	2021	13	90733	453.7	2179	10.9	88554	442.7
			2022	13	8388	41.9	0	-	8388	41.9
1	Улсын эмнэлгийн дүн	Ковид тандалт -5000	2021	1	10303	51.5	142	0.7	10161	50.8
			2022	1	3407	17.0	2	0.01	3405	17.0
1	Улсын эмнэлгийн дүн	Ковид сорьц-5000	2021	1	10303	515.2	142	7.1	10161	508.1
			2022	1	3407	170.4	2	0.1	3405	170.2
	НИЙТ ДҮН		2021	51	187522	9,146.6	10183	1,449.5	177339	7,697.1
2022			45	20435	1,478.8	276	184.3	20159	1,294.3	

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЭМДХ-ийн 2021-2022 оны тайлан

Ковид-19 цар тахал, коронавируст халдварын үед эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлсэн, гэрийн тусгаарлалтын эмчилгээ хийлгэсэн болон ковид-вакцин, ковид-тандалт, ковид-сорьц авахтай холбогдуулан 2021 онд давхардсан тоогоор нийт 51 эрүүл мэндийн байгууллагаас нийтдээ 187,522 даатгуулагчид үзүүлсэн 9,145.6 сая төгрөгийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилснээс эмч, байцаагчийн болон системийн хяналтаар 10,183 тохиолдолд үзүүлсэн 1,449.5 сая төгрөгийн нэхэмжлэлд хасалт хийгдэж (нэхэмжилсэн хүний тоотой харьцуулахад 5.4 хувь, мөнгөн дүнтэй харьцуулахад 0.7 хувь), 177,399 тохиолдолд 7,697.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцоо нийлсэн байна.

2022 онд давхардсан тоогоор нийт 45 эрүүл мэндийн байгууллагаас нийт 20,435 иргэнд үзүүлсэн 1,478.8 сая төгрөгийн тусламж, үйлчилгээний зардал нэхэмжилснээс 276 иргэнд үзүүлсэн 184.3 сая төгрөгийн нэхэмжлэлд хасалт хийгдэж (нэхэмжилсэн хүний тоотой харьцуулахад 1.3 хувь, мөнгөн дүнтэй харьцуулахад 0.9 хувь), 20,159 тохиолдолд 1,294.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон байна.

Б.1.3. Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь тусдаа төсөвгүй, хүний нөөцийн дутагдалтай ажиллаж ирсэн байна

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 4 орон тоогоор /хэлтсийн дарга 1, чанар төлбөрийн хяналтын мэргэжилтэн 3/ аймгийн хэмжээнд даатгалын гэрээ бүхий эрүүл мэндийн

байгууллага, эмийн сангуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг босоо удирдлагатай байгууллага байна.

Хэлтэс нь үйл ажиллагааны тусдаа төсөвгүй бөгөөд үйл ажиллагааны зардлын /шуудан, интернэтийн төлбөр, утасны төлбөр гэх мэт/ нэхэмжлэлийг сар бүр ЭМДЕГ-ын санхүүгийн хэлтэст хүргүүлж, төлбөр тооцоог гүйцэтгэдэг байна.

ЭМДЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “ЭМДЕГ бүтцийн нэгж ажил албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” А/10 тушаалаар тус ЭМД-ын хэлтсийн орон тоог 5 хүнээр баталсан боловч одоо 1 орон тоо дутуу буюу 4 орон тоогоор ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 70 дугаар тогтоолоор баталсан аймгийн Эрүүл мэндийн хэлтсийн “чанар, төлбөрийн хяналтын мэргэжилтэн”-ий ажлын байрны тодорхойлолтын албан тушаалд тавигдах тусгай шаардлагад эрүүл мэнд, бизнес ба удирдахуй, эрх зүй, эдийн засаг статистик зэрэг мэргэжилтэй байхаар тусгасан байна.

Тус аймагт одоо 2 эмч, 2 санхүүгийн мэргэжилтэй хүн ажиллаж байгаа ба эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн түүвэрлэгдсэн өвчний түүхэнд оношны хамааралтай бүлэг бүхэнд тохирсон шалгуур үзүүлэлтээр цахим нарийвчилсан хяналтыг хэрэгжүүлэхэд эмч, эмнэлгийн нарийн мэргэжил нэн шаардлагатай байдаг байна.

Тус аймгийн ЭМД-ын хэлтсийн сул орон тоонд ажиллах төрийн албаны ерөнхий шалгалт өгсөн нөөцөд байгаа эмч мэргэжилтэй хүн байхгүйтэй холбоотой Төрийн албаны зөвлөлийн ажлын байрны тодорхойлолтод заасан бусад тусгай мэргэжлийн хүн шалгарч орж ирэх магадлалтай байдаг байна.

Төрийн албаны зөвлөлийн ажлын байрны тодорхойлолтод заасан эмч, санхүүч мэргэжлийг салгаж тухайн аймагт шаардлагатай мэргэжилтэй хүнийг сонгох талаар холбогдох байгууллагуудад хандаж, арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Б.1.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын сонгон шалгаруулалтыг ЭМДЕГ-аас зохион байгуулсан байна

Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, 16.1.4-т заасан үүргийнхээ дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь 2021 онд өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвөөс зарим сэргээн засах тусламж, үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх төв, орон нутгийн өрх, сум, тосгоны Эрүүл мэндийн төвүүдийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг улсын хэмжээнд 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулсан байна.

Сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг цахим вэб сайтаар мэдээлж, урилгыг "Зууны мэдээ" сонинд нийтэлсэн байна.

2022 оноос гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн журамд шилжсэнтэй холбоотой ЭМДҮЗ-ийн 2022 оны 01-р тогтоолын дагуу Худалдан авалт гэрээлэлтийн газар /ХАГГ/-с лавлагаа шатлалын эмнэлгийн сонгон шалгаруулалтыг 2022 оны 5 дугаар сараас эхлэн улсын хэмжээнд 2 үе шаттайгаар зохион байгуулжээ.

Энэхүү сонгон шалгаруулалтад аймгийн Нэгдсэн эмнэлэг, “Сансар” эмнэлэг болон 6 хувийн эмнэлэг орж, тодорхой тусламж үйлчилгээний төрлөөр, оношны хамааралтай бүлэг /ОХБ/-ээр тэнцсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын А/15 дугаар тушаалаар Бугат сумын ЭМТ “оношилгоо, шинжилгээний тусламж үйлчилгээ”, Цэнгэл сумын ЭМТ “Сэргээн засах тусламж үйлчилгээ” үзүүлэх сонгон шалгаруулалтад тэнцсэн байна.

Бугат сумын ЭМТ 2022 оны 5 дугаар сараас оношилгоо, шинжилгээний тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан байна. Цэнгэл сумын ЭМТ 2022 онд сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлээгүй байна.

ЭМДЕГ-с ирүүлсэн чиглэлийн дагуу аймгийн ЭМДХ-ийн дарга, мэргэжилтнүүд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим өндөр өртөгтэй оношны хамааралтай бүлгийн сонгон шалгаруулалттай холбоотой дээр эрүүл мэндийн байгууллагуудад газар дээр нь ажиллаж, эмнэлгийн хүчин чадал, хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгаа хийж мэдээллээр хангаж, холбогдох тайлан, нэгтгэлийг хүргүүлсэн байна.

ЭМДЕГ-ын Худалдан авах гэрээлэлтийн газар сонгон шалгаруулалт, гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулж гэрээний нэг хувийг тухайн гэрээ хийсэн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын гэрээлэлтийн газрын “selection.1818.mn” вэб сайтад сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн байгууллагуудын гэрээ, гэрээний хавсралтууд болон холбогдох бусад материалуудыг байршуулсан нь тухайн эрүүл мэндийн байгууллага өөрсдийн хувийн код, нууц үгээр орж сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг бүрэн авах боломжтой болсон байна.

Аудитын явцад аймгийн Нэгдсэн эмнэлэг нь сэргээн засах хэвтүүлэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний сонгон шалгаруулалтад тэнцээгүй байгааг тодруулж үзэхэд дараах байдалтай байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сэргээн засах тасаг нь 88.5 м.кв талбай бүхий 3 өрөө, 6 ортой хэвтэн эмчлэх сэргээн засах эмчилгээ, үйлчилгээ явуулах стандартыг хангасан байртай боловч сэргээн засахын нарийн мэргэшлийн эмч бэлтгэгдээгүй, хүний нөөцийн шаардлага хангаагүйгээс сонгон шалгаруулалтад тэнцээгүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг 2022 онд 4018 өвчтөнд сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэн нь сэргээн засах хэвтүүлэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ иргэдэд нэн шаардлагатай байгааг харуулж байгаа ба сэргээн засахын оношны хамааралтай бүлгээр мэргэшсэн эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэх талаар анхаарах шаардлагатай байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд ЭМДЕГ-ын Худалдан авах гэрээлэлтийн газар 2021-2022 онуудад оношны хамааралтай бүлэг /ОХБ/-ээр эрүүл мэндийн байгууллагуудын сонгон шалгаруулалтыг зохих журмын зохион байгуулсан байна.

Б.1.5. Өрх, сумын Эрүүл мэндийн төв, төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 2022 оны гэрээг дүгнээгүй байна

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар 2021 онд төрийн өмчийн 1, хувийн хэвшлийн 6, өрхийн эмнэлэг 4, сум, тосгоны эмнэлэг 13, рашаан сувилал 1, эмийн сан 49, бүгд 74 байгууллагатай, 2022 онд төр өмчийн 2, хувийн хэвшлийн 6, өрхийн эмнэлэг 4, сум, тосгоны эмнэлэг 13, рашаан сувилал 1, эмийн сан 53, бүгд **79** эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тус тус гэрээ байгуулан ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн А/03 дугаар тушаалаар Эрүүл мэндийн ерөнхий газар болон эрүүл мэндийн байгууллага хооронд 2021 оны “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс зарим эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ”-ний жилийн эцсийн биелэлтийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, гэрээ дүгнэх ажлын удирдамж, гэрээ дүгнүүлэх эрүүл мэндийн байгууллагын нэрсийн жагсаалтыг баталсан байна.

Дээрх тушаалаар баталсан гэрээ дүгнүүлэх эрүүл мэндийн байгууллагын нэрсийн жагсаалт, үйлчилгээний төрлийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №12

Д/д	Байгууллагын нэр	Анхан шатны тусламж үйлчилгээ				Элэгний В.С илрүүлэг	Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэлт оношилгоо шинжилгээ	Хэвтүүлэн эмчлэх
		Сэргээн засах тусламж үйлчилгээ	Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ	Өдрийн эмчилгээ, үйлчилгээ	Оношилгоо шинжилгээ			
1	Жансая ӨЭМТ	1	1	1	1	1	1	0
2	Мейрим ӨЭМТ	1	1	1	1	1	1	0
3	Раушан ӨЭМТ	1	1	1	1	1	1	0
4	Шипагер ӨЭМТ	1	1	1	1	1	1	0
5	Алтай СЭМТ	0	1	1	1	1	1	0
6	Алтанцөгц СЭМТ	0	1	1	0	1	1	0
7	Баяннуур СЭМТ	1	1	1	1	1	1	0
8	Бугат СЭМТ	0	1	1	0	1	1	0
9	Булган СЭМТ	0	1	1	1	1	1	0
10	Буянт СЭМТ	1	1	1	1	1	1	0
11	Сагсай СЭМТ	0	1	1	1	1	1	0
12	Толбо СЭМТ	1	1	1	1	1	1	0
13	Улаанхус СЭМТ	0	1	1	1	1	1	0
14	Цагааннуур СЭМТ	0	1	1	1	1	1	0
15	Дэлүүн СЭМТ	0	1	1	1	1	1	0
16	Ногооннуур СЭМТ	0	1	1	1	1	0	0
17	Цэнгэл СЭМТ	0	1	1	1	1	1	0
ДҮН		7	17	17	15	17	16	0

Эх сурвалжийг: ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/03 тоот тушаалын хавсралт

ЭМДЕГ-ын 2022 оны А/03 дугаар тушаалаар даалгасны дагуу аймгийн ЭМДХ-ээс сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн 17 байгууллага, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, өдрийн эмчилгээ, үйлчилгээ,

оношилгоо шинжилгээ үйлчилгээ, элэгний В,С илрүүлэг үйлчилгээ, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэлт оношилгоо шинжилгээ зэрэг үйлчилгээ үзүүлсэн байгууллагуудын гэрээний биелэлтийг зохих журмын дагуу үнэлж, дүгнэн баталгаажуулж файл болон цаасаар ЭМДЕГ-т хүргүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/16 дугаар тушаалаар Эрүүл мэндийн ерөнхий газар болон эрүүл мэндийн байгууллага хооронд 2021 оны **“төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас зарим эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ”**-ний жилийн эцсийн биелэлтийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон гэрээ дүгнэх ажлын удирдамжийг баталсан байна.

Дээрх тушаалын хавсралтад тус аймгийн Нэгдсэн эмнэлэг, “Сансар” эмнэлэг, “Жаншарапат”, “Нурлы”, “Фатиха”, “Бейс-шипа”, “Нур-Алтай мед” хувийн хэвшлийн эмнэлэг, “Ахсу” сувилал хамрагдахаар заасан байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтууд болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/142 дугаар тушаалаар баталсан “Даатгалын гэрээ дүгнэх журам”-ыг үндэслэн 2021 оны даатгалын гэрээний биелэлтийг дүгнэсэн байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, “Сансар” эмнэлэг, “Жаншарапат”, “Нурлы”, “Фатиха”, “Бейс-шипа”, “Нур-Алтай мед” хувийн хэвшлийн эмнэлгүүд 80-100 оноогоор “хангалттай” гэсэн үнэлгээ авч Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/31 дүгээр тушаалаар баталгаажуулсан байна.

ЭМДЕГ-аас “Даатгалын гэрээ дүгнэх журам”-ын 3 дахь хэсгийн 3.1.1-д “Даатгалын гэрээ дүгнэсэн үнэлгээний нийлбэр нь 81-100 оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагатай даатгалын гэрээг үргэлжлүүлэх, шинэчлэн байгуулж болно” гэсэн заалтын дагуу эрүүл мэндийн байгууллагатай даатгалын гэрээг хэвээр үргэлжлүүлэх, шинэчлэн байгуулах талаар ирүүлсэн чиглэлийг үндэслэн 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр гэрээг байгуулан ЭМДЕГ-ын дарга, эрүүл мэндийн байгууллага, эмийн сангуудын дарга, эрхлэгч нар гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Тус аймгийн 2021 оны даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагуудаас хангалтгүй үнэлгээ авсан болон гэрээ дүгнүүлэхээр материал хүргүүлээгүй байгууллага байхгүй байна.

2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-г тогтоосонтой холбоотой дахин сонгон шалгаруулалт зохион байгуулж оношны хамааралтай бүлэг /ОХБ/-ээр тэнцсэн аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хилийн цэргийн 0165 дугаар анги, “Сансар” эмнэлэг, “Ахсу” рашаан сувилал, “Жаншарапат”, “Бэйсшипа”, “Нур-Алтай мед”, “Нурлы”, “Фатиха” эмнэлэг зэрэг 9 төр, хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд болон рашаан сувиллын газрыг 2022 оны 9 дүгээр сард 3 жилийн хугацаатай мөрдөхөөр гэрээг шинэчлэн байгуулсан байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр тэнцэж Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай 2022 оны 09 дүгээр сард гэрээ байгуулсан Хилийн цэргийн 0165 дугаар анги нь программыг ашиглаж холбогдох материалыг зохих журмын дагуу илгээгээгүй бол “Ахсу” рашаан сувилал улирлын чанартай үйл ажиллагаа явуулдагтай холбоотой 2022 онд ЭМДС-гаас санхүүжилт аваагүй байна.

Харин бусад эрүүл мэндийн байгууллагууд гэрээнд заасан эрх үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтыг “Даатгуулагч Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.9, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллагын эмчийн бичсэн жороор эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон ерөнхий нэршлийн эмийг тухайн эрүүл мэндийн байгууллагын эмийн сан, бусад эмийн сангаас худалдан авах тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлнэ” гэж өөрчлөн найруулан 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан байна.

Тус аймгийн эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулах хүсэлт гаргасан эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем (НӨАТУС)-ийн баримт олгодог 2021 онд 49 , 2022 онд 53 эмийн сантай эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээг тус тус байгуулсан байна.

ЭМДЕГ-аас 2021 онд сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн байгууллагуудад гэрээ байгуулж, дүгнэхдээ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон эмийн сантай даатгалын гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г байгуулах бөгөөд гэрээний хэрэгжилтийг хянаж, дүгнэнэ” гэсэн заалт, ЭМДЕГ-ын даргын 2018 оны А/142 дугаар тушаалаар “Даатгалын гэрээ дүгнэх журам”, бусад холбогдох эрх зүйн актуудыг мөрдөж ажилласан байна.

Аймгийн ЭМДХ 2021 оны эрүүл мэндийн байгууллагуудын гэрээ дүгнэсэн баталгаажилтын хуудсыг 2 хувь хэвлэн нэг хувийг нэгтгэл тайлангийн хамт ЭМДЕГ-ын ХАГГ-т, нэг хувийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн байна.

Эрүүл мэндийн ерөнхий газар 2022 онд эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс зарим эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ”, “төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас зарим эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ”-ний жилийн эцсийн биелэлтийг дүгнээгүй байна. Харин эмийн сангуудын 2022 оны гэрээний биелэлтийг 2023 оны 2 сард дүгнэсэн байна.

ЭМДЕГ 2021 онд тус аймгийн 49 эмийн сантай гэрээ байгуулж нийт 3,899.7 сая төгрөгийн, 2022 онд 53 эмийн сантай гэрээ байгуулж 2,172.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь өмнөх оноос эмийн сангуудад олгох хөнгөлөлттэй эмийн санхүүжилт 1,726.9 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь ЭМДЕГ-аас 2022 оны 7 дугаар сард 17 эмийн сангийн гэрээг түр түдгэлзүүлж эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилт олгоогүй, зарим эмийн үнийн хөнгөлөгдөх хувь хэмжээ буурсантай холбоотой байна.

ЭМДЕГ-ын дарга, Эрүүгийн цагдаагийн албаны даргын хамтарсан удирдамжаар 2022 оны 7 дугаар сард хяналт шалгалтын 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тус аймагт ажиллаж хамгийн их санхүүжилт авсан 18 эмийн санд хяналт шалгалт хийж 17 эмийн сангийн хөнгөлөлттэй жор олгох эрхийг цахим системд хааж гэрээг нь түр түдгэлзүүлсэн байна.

ЭМДЕГ-тай 2022 онд эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлэх гэрээ хийсэн “Мед” эмийн сан хөнгөлөлттэй эмээр үйлчилгээ үзүүлээгүй байна.

ЭМДЕГ-ын даргын 2023 оны А/01 тоот тушаалыг үндэслэн аймгийн ЭМДХ-ийн ажлын хэсэг 2023 оны 1-2 дугаар сард ЭМДЕГ-ын төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдаагүй 34, хамрагдсан 1, бүгд 35 эмийн сангийн 2022 оны “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-г дүгнэсэн байна.

Хүснэгт №13

№	Сумын нэр	Хуулийн этгээдийн нэр	Эмийн сангийн нэр	Үнэлгээ
1	Дэлүүн	Тод саран фарм ХХК	Анар	75
2	Өлгий	Ахмад энх ХХК	Ахмадын	85
3	Өлгий	Байбулган ХХК	Байбулган	85
4	Өлгий	Дөрвөн эрдэнэ фарм ХХК	Биофарм	75
5	Өлгий	Дара ХХК	Дара	75
6	Баяннуур	Емен ХХК	Емен	85
7	Өлгий	Ерма ХХК	Ерма	85
8	Өлгий	Ермика ХХК	Ермика	90
9	Өлгий	Ерту ХХК	Ерту	85
10	Өлгий	Коскос ХХК	Коскос	80
11	Өлгий	Мөнхийн тун ХХК	Мөнхийн тун	85
12	Өлгий	Нурлы ХХК	Нурлы эмийн сан	55
13	Өлгий	Олон мод фарм ХХК	Олон мод фарм	0
14	Өлгий	Өлгий хужирт ХХК	Өлгий хужирт	65
15	Булган	Сапаржай ХХК	Сапаржай	0
16	Өлгий	Хашаатын цагаан чулуут ХХК	Тод фарм	65
17	Өлгий	Ушкын ХХК	Ушкын	85
18	Өлгий	Энэрэлт саран ээж ХХК	Харахат	65
19	Цэнгэл	Хурган нуур зам ХХК	Цэнгэл фарм	65
20	Улаанхус	Ах тилек ТББ	Шугыла	60
21	Өлгий	Баян-Өлгий эм хангамж ХХК	Эм импекс	85
22	Өлгий	Энэрэл ХХК	Энэрэл	55
23	Дэлүүн	Табигат хоршоо	Яргуй	0
24	Өлгий	Вест өлгий консракшн ХХК	Юнимед	85
25	Алтай	Алтай сумын ЭМТөв	Алтай сумын ЭЭСан	85
26	Алтанцөгц	Алтанцөгц сумын ЭМТөв	Алтанцөгц сумын ЭЭСан	85
27	Бугат	Бугат сумын ЭМТөв	Бугат сумын ЭЭСан	85
28	Булган	Булган сумын ЭМТөв	Булган сумын ЭЭСан	85
29	Дэлүүн	Дэлүүн сумын ЭМТөв	Дэлүүн сумын ЭЭСан	85
30	Ногооннуур	Ногооннуур сумын ЭМТөв	Ногооннуур сумын ЭЭСан	85
31	Сагсай	Сагсай сумын ЭМТөв	Сагсай сумын ЭЭСан	85
32	Толбо	Толбо сумын ЭМТөв	Толбо сумын ЭЭСан	85
33	Улаанхус	Улаанхус сумын ЭМТөв	Улаанхус сумын ЭЭСан	85
34	Цагааннуур	Цагааннуур сумын ЭМТөв	Цагааннуур сумын ЭЭСан	85
35	Өлгий	Бес харагай ЭМТөв	Дуалы	0
		НИЙТ		35

Эх сурвалж: аймгийн ЭМДХ

Аймгийн ЭМДХ-ийн дарга, мэргэжилтнүүд оролцсон ажлын хэсгийн холбогдох журам, зааврыг үндэслэн дүгнэж 80-90 оноогоор дүгнэгдсэн 20 эмийн санд зөвлөмж, 60-75 оноогоор дүгнэгдсэн 8 эмийн санд албан шаардлага хүргүүлж, 55 оноо авсан 2 эмийн сангийн гэрээг цуцалсан байна. “Олон мод фарм”, “Сапаржай”, “Яргуй”, “Дуалы” зэрэг 4 эмийн сан шаардлагатай баримт материалаа ирүүлж гэрээгээ дүгнүүлээгүй байна.

Ажлын хэсэг 2022 онд гэрээ байгуулсан “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-г дүгнэхэд 60-75 хувиар хангалтгүй дүгнүүлсэн 8 эмийн санд 3-4 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлагыг 15 хоногийн хугацаатай хүргүүлж, албан шаардлагын биелэлтийг хангуулж ажилласан байна.

ЭМДЕГ-т албан шаардлагын биелэлтийг ханган ирүүлсэн 7 эмийн сангийн гэрээг үргэлжлүүлэн байгуулж цахим системд эрхийг нээлгэх, албан шаардлагын биелэлтийг хангаж ажиллаагүй “Өлгий хужирт” эмийн сангийн гэрээг цуцлах, цахим системд эрхийг хаалгах саналыг албан бичгээр хүргүүлсэн байна

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, гүйцэтгэлийг холбогдох журам зааврын дагуу дүгнэж ажилласан байна.

Б1.6. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн шинэчилсэн бодлогын үр дүнд эрүүл мэндийн байгууллагуудад олгож байгаа санхүүжилт нэмэгдсэн боловч эрүүл мэндийн байгууллагуудаас иргэд даатгуулагчдад үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний хүртээмжтэй байдалд үзүүлэх үр нөлөө бага байна

Эрүүл мэндийн байгууллагуудад олгосон тайлант оны нийт санхүүжилтийг 2020 онд олгосон санхүүжилттэй харьцуулахад 9,903.5 сая төгрөгөөр буюу 48 хувь, 2021 онтой харьцуулахад 5,208.9 сая төгрөгөөр буюу 20.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт №14 Эрүүл мэндийн байгууллагуудад 2020-2022 онд олгосон санхүүжилтийн гүйцэтгэл (сая төгрөг)

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	Олгосон санхүүжилт			зөрүү 2020-2022	зөрүү 2021-2022
		2020 он	2021 он	2022 он		
1	Улсын эмнэлэг-1	9,456.3	11,169.8	12,753.8	3,297.5	1,584.0
2	Хувийн эмнэлэг-6	2,216.3	4,303.3	5,053.0	2,836.7	749.7
3	СЭМТӨВ-13	7,614.4	8,493.2	10,463.7	2,849.3	1,970.5
4	ӨЭМТӨВ-4	1005.8	1,021.1	1,925.8	920.0	904.7
Дүн		20,292.8	24,987.4	30,196.3	9,903.5	5,208.9

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЭМДХэлтсийн 2020-2022 оны тайлан

Тайлбар: Ковид-19 цар тахлын эсрэг эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан санхүүжилтийг 2021-2022 оны үзүүлэлтээс хасаж тооцов.

Эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилтийн талаар:

Гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2022 онд олгосон санхүүжилтийг 2020 онтой харьцуулахад 3,297.5 сая төгрөгөөр буюу 34.9 хувиар, 2021 оны санхүүжилттэй харьцуулахад 1584.0 сая

төгрөгөөр буюу 14.2 хувиар, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд олгосон санхүүжилтийг 2020 онтой харьцуулахад 2,836.7 сая төгрөг буюу 128 хувиар, 2021 онтой харьцуулахад 749.7 сая төгрөг буюу 17.4 хувиар, сумын Эрүүл мэндийн төвүүдийн санхүүжилт 2020 онтой харьцуулахад 2,849.3 сая төгрөгөөр буюу 37.4 хувиар, 2021 онтой харьцуулахад 1,970.5 сая төгрөг буюу 23.2 хувиар, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн санхүүжилт 2020 онтой харьцуулахад 920.0 сая төгрөг буюу 91.5 хувиар, 2021 онтой харьцуулахад 904.7 сая төгрөг буюу 88.6 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Өрхийн эмнэлгүүдэд 2022 онд олгосон санхүүжилт нь өмнөх онуудаас 2 дахин нэмэгдсэн нь ЭМДҮЗ-ийн 2022 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 5 дугаар тогтоолоор нэг иргэнээр тооцох төлбөрийн хэмжээг хоёр дахин нэмсэнтэй, мөн хэвтүүлэн, шүд, түргэн болон яаралтай тусламжийн үйлчилгээний тарифыг лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх, багц төлбөрийн аргаар тооцож олгосонтой холбоотой байна.

Хувийн хэвшлийн эмнэлгүүдэд 2021 онд олгосон гүйцэтгэлийн санхүүжилт нь өмнөх оноос мөн 2 дахин нэмэгдсэн нь ЭМДҮЗ-ийн 2021 оны “ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-г баталсан 03 дугаар тогтоолоор хувийн эмнэлгүүд нь улсын эмнэлэгтэй ижил тарифаар тусламж, үйлчилгээ үзүүлэх болсонтой холбоотой байна.

Эрүүл мэндийн байгууллагуудад үйлчлүүлсэн иргэд (тохиолдол)-ийн талаар:

Эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны тохиолдлын тоог 2020 оны үзүүлэлттэй харьцуулахад 914 тохиолдлоор буурсан, 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад 3916 болж өссөн байна.

2021 оны тохиолдлын тоо нь өмнөх оноос 914 тохиолдлоор буурсан нь Ковид-19 цар тахлын өвчний дэгдэлттэй холбоотой байна. (Ковид-19 цар тахлын үед эмчлүүлсэн тохиолдлын тоог судалгааны тоонд оруулаагүй)

Хүснэгт №15 Эрүүл мэндийн байгууллагуудын 2020-2022 оны тохиолдлын тоо. (сая төгрөг)

№	Эрүүл мэндийн байгууллагын төрөл	Тохиолдлын тоо			зөрүү 2020-2022	зөрүү 2020-2022
		2020 он	2021 он	2022 он		
1	Улсын эмнэлэг	176,553	170,777	170,030	(6,523)	(747)
2	Хувийн эмнэлэг	8,050	8,734	11,253	3,203	2,519
3	СЭМТөв	7,806	7,692	9,539	1,733	1,847
4	ӨЭМТөв	3,558	3,934	4,231	673	297
Дүн		195,967	191,137	195,053		

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЭМДХ-ийн 2020-2022 оны тайлан

Тайлбар: Ковид-19 цар тахлын эсрэг эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдлын тоог 2021-2022 оны үзүүлэлтээс хасаж тооцов.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн тайлант оны тохиолдлын тоог 2020 онтой харьцуулахад 6523 тохиолдлоор, 2021 онтой харьцуулахад 747 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

Харин хувийн хэвшлийн эмнэлгүүдийн тохиолдлын тоог 2020 онтой харьцуулахад 3,203 тохиолдлоор буюу 39.8 хувь, 2021 онтой харьцуулахад 2,519 буюу 28.8 хувиар, сумын Эрүүл мэндийн төвүүдийн тохиолдлын тоог 2020 онтой харьцуулахад 1,733 тохиолдлоор буюу 22.2 хувь, 2021 онтой харьцуулахад 1,847 буюу 24 хувиар, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн тохиолдлын тоог 2020 онтой харьцуулахад 673 буюу 18.9 хувь, 2021 онтой харьцуулахад 297 буюу 7.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн тохиолдлын тоог бусад эмнэлгийн байгууллагуудын тохиолдлын тоотой харьцуулахад дунджаар 34.3 хувиар нэмэгдсэн нь гүйцэтгэлийн санхүүжилтийг улсын эмнэлгийн санхүүжилттэй ижил тарифаар авдаг болсонтой холбоотой байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын цалингийн зардлын талаар:

Эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны цалингийн зардал нь 2020 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 3,773.9 сая төгрөг буюу 27.6 хувиар, 2021 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2,172.9 сая төгрөг буюу 14.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт:№16 Эрүүл мэндийн байгууллагуудад 2020-2022 оны цалингийн зардлын гүйцэтгэл (сая төгрөг)

ЭМБ-ын төрөл	Цалин хөлс, нэмэгдэл			зөрүү 2020-	
	2020 он	2021 он	2022 он	2022	зөрүү 2021-2022
Улсын эмнэлэг	6,825.5	7,584.6	8,630.9	1,805.4	1,046.3
СЭМТөв	6,001.8	6,738.1	7,209.5	1,207.7	471.4
ӨЭМТөв	828.4	933.7	1,588.9	760.5	655.2
Дүн	13,655.7	15,256.4	17,429.3	3,773.6	2,172.9


Эх сурвалж: ЭМ-ийн байгууллагуудын 2020-2022 санхүүгийн тайлан

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны цалингийн зардлыг 2020 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 1,805.4 сая төгрөг буюу 26.4 хувиар, 2021 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 1046.3 сая төгрөг буюу 13.7 хувиар, сумын Эрүүл мэндийн төвүүдийн цалингийн зардал 2020 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 1,207.7 сая төгрөг буюу 20.1 хувиар, 2021 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 471.4 сая төгрөг буюу 6.9 хувиар, Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн цалингийн зардал 2020 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 760.5 сая төгрөг буюу 91.8 хувиар, 2021 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 655.2 сая төгрөг буюу 70.1 хувиар тус тус өссөн байна.

Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн цалингийн зардал дунджаар 81 хувиар нэмэгдсэн нь нэг иргэнээр тооцох төлбөрийн хэмжээ 2 дахин нэмэгдсэнийг үндэслэн нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар албан хаагчдын цалинг нэмсэнтэй холбоотой байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвүүдийн цалин зохих хэмжээгээр нэмэгдсэн боловч дорвитой өөрчлөлт ороогүй байна.

График №02 ЭМБ-уудын 2020-2022 оны цалингийн гүйцэтгэл



Эрүүл мэндийн байгууллагуудын үндсэн хөрөнгийн өөрчлөлтийн талаар:

Эрүүл мэндийн байгууллагуудын үндсэн хөрөнгө 2020 онтой харьцуулахад 460.8 сая төгрөгөөр буюу 4.8 дахин, 2021 онтой харьцуулахад 332.1 сая төгрөгөөр буюу 2.3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт №17. Эрүүл мэндийн байгууллагуудын 2020-2022 оны үндсэн хөрөнгө (сая төгрөг)

ЭМБ-ын төрөл	Үндсэн хөрөнгө			зөрүү 2020-2022	зөрүү 2021-2022
	2020 он	2021 он	2022 он		
Улсын эмнэлэг	23.7	48.1	105.5	81.8	57.4
СЭМТөв	30.1	124.2	359.9	329.8	235.7
ӨЭМТөв	64.7	74.9	113.9	49.2	39.0
Дүн	118.5	247.2	579.3	460.8	332.1

Эх сурвалж: ЭМ-ийн байгууллагуудын 2020-2022 санхүүгийн тайлан

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны үндсэн хөрөнгийн мөнгөн дүнг 2020 онтой харьцуулахад 81.8 сая төгрөг буюу 4.4 дахин, 2021 онтой харьцуулахад 57.4 сая төгрөг буюу 2.2 дахин, сумын Эрүүл мэндийн төвүүдийн үндсэн хөрөнгийн дүнг 2020 онтой харьцуулахад 329.8 сая төгрөг буюу 12 дахин, 2021 онтой харьцуулахад 57.4 сая төгрөг буюу 2.9 дахин, Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн үндсэн хөрөнгийн дүнг 2020 онтой харьцуулахад 49.2 сая төгрөг буюу 1.7 дахин, 2021 онтой харьцуулахад 39.0 сая төгрөг буюу 1.5 дахин тус тус нэмэгдсэн байна.

Энэ нь эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдсэн, нөгөө талаас үндсэн хөрөнгийн шинэчлэл хийх боломж бүрдэж, нэхэмжлэлийн хяналтыг цахимжуулахтай холбоотой компьютер, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн, шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг худалдан авсантай холбоотой байна.

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авагч тал буюу ЭМДЕГ нь ЭМБ-аас чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг болсон, үзүүлж буй тусламж,

үйлчилгээ нь шаардлага хангаагүй тохиолдолд санхүүжилт олгодоггүй болсонтой холбогдуулан ЭМБ-ын хооронд өрсөлдөөн бий болж, үндсэн хөрөнгийн шинэчлэл хийж эхэлсэн байна.

Хүснэгт №18 Эрүүл мэндийн байгууллагуудын 2020-2022 оны үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй (сая төгрөг)

ЭМБ-ын төрөл	огноо	Төсвийн хөрөнгө, ЭМД-ын санхүүжилтээр худалдан авсан үндсэн хөрөнгө	Үүнээс:			
			Эмнэлгийн тоног төхөөрөмж	Компьютер тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил	Бусад
Улсын эмнэлэг	2020	23.7	1.6	8.9	10.3	2.8
	2021	48.1	3.5	38.2	3.4	3.0
	2022	105.6	11.2	77.7	16.7	
ӨЭМТөв	2020	64.7	26.1	27.0	11.5	
	2021	74.9	32.6	21.9	20.4	
	2022	113.9	70.6	19.1	24.2	
СЭМТөв	2020	30.2	6.9	18.2	5.1	
	2021	124.2	8.5	77.1	31.2	7.3
	2022	359.9	125.8	185.5	40.6	8.1
Нийт дүн	2020	118.6	34.6	54.1	26.9	2.8
	2021	247.2	44.6	137.2	55.0	10.3
	2022	579.4	207.6	282.3	81.5	8.1

Эх сурвалж: ЭМ-ийн байгууллагуудын 2020-2022 санхүүгийн тайлан

Судалгаанаас харахад 2020 онд Эрүүл мэндийн байгууллагууд эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад 34.6 сая төгрөг буюу нийт үндсэн хөрөнгийн 29.1 хувь, компьютер тоног төхөөрөмж худалдан авахад 54.1 сая төгрөг буюу 45.6 хувь, тавилга эд хогшил худалдан авахад 26.9 сая төгрөг буюу 22.6 хувь, 2021 онд эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад 44.6 сая төгрөг буюу 18.0 хувь, компьютер тоног төхөөрөмж худалдан авахад 137.2 сая төгрөг буюу 55.5 хувь, тавилга эд хогшил худалдан авахад 55.0 сая төгрөг буюу 22.2 хувь, 2022 онд эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад 207.6 сая төгрөг буюу 35.8 хувь, компьютер тоног төхөөрөмж худалдан авахад 282.3 сая төгрөг буюу 48.7 хувь, тавилга эд хогшил худалдан авахад 81.5 сая төгрөг буюу 14.0 хувийг тус тус зарцуулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн шинэчилсэн бодлогын үр дүнд эрүүл мэндийн байгууллагуудад олгож байгаа санхүүжилт, үүнийг дагаж ажилтнуудын цалин, тоног төхөөрөмж шинэчлэх асуудал тодорхой хэмжээгээр шийдэгдэж байгаа боловч төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж байгаа эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжтэй байдалд үзүүлж буй үр нөлөө бага байна.

Хүснэгт 10, 11-ээс харахад анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагууд (Өрхийн болон сумын Эрүүл мэндийн төв) нь 2020 онд ЭМБ-д олгосон нийт санхүүжилтийн 42.4 хувийг, 2021 онд санхүүжилтийн 38 хувийг, 2022 онд мөн санхүүжилтийн 41 хувьтай тэнцэх хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилт авч байгаа боловч ЭМБ-ын нийт ачааллын (тохиолдол) 2020 онд ердөө 5.7 хувь, 2021 онд 6.0 хувь, 2022 онд 7.0 хувийг үүрч байна.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын авч буй нийт санхүүжилттэй харьцуулахад 2020 онд 18.9 хувь, 2021 онд 27.8 хувь, 2022 онд 28.3 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилт авч байгаа боловч нийт ачааллын (тохиолдол) 2020 онд 4.3 %, 2021 онд 4.8 %, 2022 онд 6.2%-ийг үүрч байна.

Дээрх судалгаанаас харахад эрүүл мэндийн байгууллагын ачааллаас хувийн хэвшлийн эмнэлэг болон анхан шатны Эрүүл мэндийн байгууллагууд хуваалцаж чадахгүй байна. Ард, иргэд улсын эмнэлэгт үзүүлэх сонирхолтой байгаа нь харагдаж байна.

Анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлдэг ЭМБ-ууд нь иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчин хүндрэхээс өмнөх үзүүлэх анхан шатны тусламж, үйлчилгээг чанартай үзүүлж чадахгүй байгаагаас хоёр дахь шатлал уруу эмчлүүлдэг иргэдийн тоо буурахгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлээр санхүүжих зарим тусламж үйлчилгээний өртгийг дахин хянаж, тарифт өөрчлөлт оруулах замаар анхан шатны тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй болгох, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын үйл ажиллагааг бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд тулгарч буй эмч нарыг чадавхжуулах асуудал хэвээрээ байна.

Иргэдээс авсан санал асуулгад нийт 442 хүн (аймгийн төвөөс 22.1%, сумуудаас 77.9%) оролцсон ба Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны өөрчлөлтийн талаарх мэдлэг, мэдээлэл нь ерөнхийдөө “дунд” байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн чанарт ямар үнэлгээ өгөх вэ? гэсэн асуултад санал асуулгад оролцсон хүмүүсийн 14 хувь нь маш сайн, 40.4 хувь нь сайн, 31.5 хувь нь дунд, 14.1 хувь нь муу гэсэн үнэлэлт өгсөн байна.

ЭМД-аар үйлчилгээ авахад ямар хүндрэл бэрхшээл тулгардаг вэ? гэсэн асуултад бүртгэлтэй холбоотой 29.2 хувь, мэдээлэл хангалтгүй 29.5 хувь, тухайн эрүүл мэндийн байгууллагын зохион байгуулалттай холбоотой 22.8 хувь, хүнд суртал чирэгдэлтэй холбоотой 17.4 хувь, бусад 9.4 хувь нь санал өгсөн байна.

Даатгуулагч та төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас хэрэгцээ шаардлагад нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чадаж байна уу? гэсэн асуултад 13.6 хувь маш сайн, 40.2 хувь сайн, 34.4 хувь дунд, 11.2 хувь муу гэсэн үнэлгээ өгсөн байна.

“Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулах тал дээр таны өгөх санал, шүүмжлэл” гэсэн асуулгад 442 иргэн оролцсоноос 103 хүн буюу 23.3 хувь нь “Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо буруу тул үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна”, 51 хүн буюу 11.5 хувь нь “Эмч нарын харьцаа нь маш муу хүнд суртал, чирэгдэл, ажлын цаг барихгүй, цагтаа ирэхгүй, эмч нарын чадварыг сайжруулах, эмнэлгийн орчныг сайжруулах, хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлагатай байна”, 21 хүн буюу 4.7 хувь нь “Хувийн хэвшлийн үйлчилгээ нь өндөр үнэ тарифтай байна”, 45 хүн буюу 10.1 хувь нь “Үйл ажиллагааг ил тод байлгах”, 40 хүн буюу 9 хувь нь “Компьютер нь дандаа сүлжээгүй байдаг”, 36 хүн буюу 8.1 хувь нь “Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтийн талаар олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүртээмжтэй

ойлгомжтой дэс дараатай мэдээлэл хүргэх”, 18 хүн буюу 4 хувь нь “Өдрийн эмчилгээ авах иргэдийн тоог хязгаарлахгүй байх” гэсэн саналуудыг өгсөн байна.

Б.2.Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой түвшинд ахиц дэвшил гарч байна

Б2.1. Малчин, айл өрх эрүүл тусламж үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын эрхэм зорилгыг “Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон.

Дэлхийн Улс орнууд Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт (цаашид БНЭМХ)-д хүрэх томоохон зорилт дэвшүүлж, БНЭМХ-д хүрэх 3 үндсэн чиглэлийг Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх, тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж багцыг өргөтгөх, нийт зардлын хувь хүний шууд төлөх төлбөрийн хэмжээг бууруулах явдал гэж тодорхойлсон байдаг.³

Эрүүл мэндийн багц хуулиудын өөрчлөлтийн зорилго нь эрүүл мэндийн бүх нийтийн хамралт буюу нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, тусламж, үйлчилгээ авахаас үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс ард иргэдийг хамгаалахад чиглэгдсэн байна.

ЭМДЕГ-ын даргын 2021 оны “Хамралтын төлөвлөгөө батлах тухай” А/10, 2022 оны А/13 дугаар тушаалаар малчид, оюутан суралцагчид, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдийн эрүүл мэндийн даатгалын хамралтын төлөвлөгөөг баталсан байна.

Баян-Өлгий аймагт шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэдийн хамрагдалт 2021 онд 5842 даатгуулагч байсан бол 2022 онд 7465 даатгуулагч болж өмнөх оноос 1623 даатгуулагч буюу 27.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт: №19 Шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг иргэдийн хамрагдалт

Үзүүлэлт	огноо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
Малчин айл, өрх	2021	8700	1705	6995	20%
	2022	7300	1778	5522	24%
Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн	2021	5000	3438	1562	69%
	2022	4500	4727	-227	105%
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч	2021	1250	699	551	56%
	2022	1400	960	440	69%
	2021	14950	5842	9108	39%


¹ Аймгийн Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл стратегийн худалдан авалт, эмнэлгийн хагас бие даасан байдлыг бэхжүүлэх чиглэлээр үндэсний хэмжээний сургагч багш бэлтгэх сургалтын гарын авлага -2022, хуудас 24)

Шимтгэлийг өөрөө хариуцан төлөх иргэд	2022	13200	7465	5735	57%
--	-------------	--------------	-------------	-------------	------------

Эх сурвалж: БӨ аймгийн НДХ-ийн 2021-2022 оны санхүүгийн тайлан

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх малчин айл, өрхийн тоог 2021 онд 8700 хүнээр төлөвлөснөөс 1705 буюу 20 хувийн гүйцэтгэлтэй, 2022 онд 7300 хүнээр төлөвлөснөөс 1778 буюу 24 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

График №03 Шимтгэлийг өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн судалгаа 2021,2022 он



Малчин айл, өрхийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалт хангалтгүй байгаа нь ард иргэдийн Эрүүл мэндийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг, эмнэлэгт үзүүлэх зайлшгүй шаардлага гарсан үед ЭМДШ-ийг төлж хэвшсэнтэй холбоотой байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн хамрагдалт 2021 онд 3438 буюу 69 хувьтай, 2022 онд 4727 буюу 105 хувьтай гарч, өмнөх оноос 1289 даатгуулагчаар нэмэгдсэн байна.

Оюутнуудын хамрагдалт 2021 онд 699 буюу 56 хувьтай, 2022 онд 960 буюу 69 хувьтай гарсан байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд болон оюутнуудын хамрагдалт өмнөх оноос нэмэгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс ард иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд байнга түгээж, facebook хуудас ашиглан постер зураг, хөдөлгөөнт постерүүд явуулж сурталчилсан, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, и-баримт ашиглаж шимтгэлийг хялбар төлөх талаар зарим сумдын иргэдтэй уулзалт зохион байгуулсан, МУБИС-ийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль, МСҮТ-ийн оюутнуудад эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн талаар сургалт зохион байгуулж, арга хэмжээ авч ажилласантай холбоотой байна.

Аудитын дүнгээр малчин айл, өрхөд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, түүний ач холбогдлын талаар олон нийтийн хэвлэл мэдээллээр байнга сурталчилж, ЭМД-ын хамрагдалтын талаарх сумын байцаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан гүйцэтгэлийг дүгнэж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

Б.2.2. Эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог хангах цахим системийн хөгжүүлэлт хангалтгүй байна

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8-д “эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх” гэж заасан байна.

2021 оноос Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний талаар даатгуулагчид чиглэсэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- ЭМДЕГ-ын МТХ-ээс цахим үйлчилгээний нэгдсэн портал “emongolia.mn”, “ebarimt.mn” системээс цаг хугацаа хэмнэн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг иргэн өөрөө цахимаар үйлчилгээний талаарх мэдээллийг хурдан шуурхай чирэгдэлгүй авах, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлөх боломжоор хангасан байна.
- 2022 оны 7 дугаар сараас ЭМДЕГ-с иргэдэд тухайн сард авсан тусламж үйлчилгээтэй холбоотой мессежээр мэдээлдэг мессеж үйлчилгээг нэвтрүүлж тухайн тусламж үйлчилгээний зардлыг аваагүй, илүү төлбөр авсан, гаднаас эм тариа авхуулсан зэрэг зөрчлүүдийг илрүүлэх боломжийг нээж өгсөн байна.

Эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн даатгалын программуудыг өөр өөрсдөө сонгон авч мэдээ мэдээллээ оруулдаг байна. Тухайлбал: Хувийн эмнэлгүүд “e-linic” программ, улсын эмнэлэг “e-health” программ ашигладаг бол өрх, сумын ЭМТ-үүд нь “health.gov.mn”, “e-hospital” программыг давхар ашигладаг байна.

Эрүүл мэндийн байгууллагууд өөр өөр программ ашиглаж байгаа нь тухайн байгууллагуудын хувьд мэдээ мэдээлэл нь нэг систем дээр хадгалагдах, нөгөө талаар урт удаан хугацаанд ашиглахад төвөгтэй байдлыг бий болгосон. Эрүүл мэндийн байгууллагууд дээрх цахим программуудын хөгжүүлэлтийг сайжруулах санал хэлж байна.

ЭМДЕГ-аас 2021 оноос “health.gov.mn” программ дээр мэдээлэл шивэх, мэдээлэл илгээх талаарх сургалт, видео бичлэг зэргийг цаг тухай бүрд нь цахим хэлбэрээр заадаг боловч орон нутгийн хувьд программын талаарх ойлголтыг бүрэн авч чадаагүйгээс программ дээрх шивэлтийн алдаа их гардаг, программын алдаанаас хасалт их хийгдэж ЭМБ-ууд санхүүжилтээ бүрэн авч чадахгүй байгаа зэрэг хүндрэлүүд гардаг байна. Иймд эрүүл мэндийн даатгалын байгууллагуудын ашиглаж байгаа “health.gov.mn” программыг илүү өргөжүүлж нэг системд төвлөрүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Эхний удаад өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ, гэрийн эмчилгээ, сэргээн засах эмчилгээг “health.gov.mn” программаар нэхэмжлэхээр болсон боловч тухайн программын шинэчлэлийн талаар ойлголт тааруу, цахим сургалт явуулж байгаа боловч үр дүн муутай байна.

Программ хөгжүүлэгч компани нь программын талаарх сургалтыг тэр бүр хийдэггүй, ЭМДҮЗ-ийн тогтоолоор тусламж үйлчилгээний өртөг өөрчлөгдөх үед, эрүүл мэндийн даатгалын цахим систем болон программ хангамжид шаардлагатай нэмэлт өөрчлөлт шинэчлэлийг тухай бүр хийдэггүй байх магадлалтай байна.

Аудитын явцад 2021, 2022 онуудын тусламж үйлчилгээний өөрчлөлтийн талаар тодруулахад Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношны хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дүгээр тогтоолоор 562 төрлийн, 2022 оны 01 дүгээр тогтоолоор 705 төрлийн оношны хамаарлын бүлгийн кодоор бүртгэхээр баталсан байна.

Өөрөөр хэлбэл ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолд оношны хамаарлын бүлгийн тоо, өдрийн мэс заслын оношийг шинээр нэмсэн, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний оношны хамааралтай бүлгийг задлан нэмж бүлэг болгон өөрчилсөнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Аудитын явцад бүрэн тогтоох боломжгүй боловч тогтоолын өөрчлөлтөөс заримыг дурдвал ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дүгээр тогтоолыг хавсралтад ОХБ-ийн 50391 кодтой, өвчний олон улсын I20 кодтой, “цээжний бах, уушгины эмболи цочмог перикардит, эндакордит” өвчний хамаарлын бүлгээр эмийн эмчилгээний заалттай бол ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолыг хавсралтад дээрх оношны хамааралтай код байхгүй өвчний олон улсын I20 код нь “зүрхний ишемит өвчин” мэс заслын заалттай.

ОХБ-ийн 122681 кодтой, өвчний олон улсын N40 кодтой өвчний хамаарлын “түрүү булчирхай томрох” бүлгээр эмийн эмчилгээний заалттай бол ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолыг хавсралтад дээрх оношны хамааралтай код байхгүй өвчний олон улсын N40 код нь “түрүү булчирхай томрох” мэс заслын заалттай гэх мэт өөрчлөлтүүд орсон байна.

Б.2.3. Даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж, өргөдөл, гомдлыг шийдвэрлэж ажилласан байна

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь “Баян-Өлгий аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэс” фейсбүүк хуудас нээж ЭМДЕГ-ын веб хуудсанд байршуулсан шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журам, мэдээ мэдээллийг цаг тухайд оруулж, иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөхийг ач холбогдол, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж, даатгуулагчийн эрх, үүргийн талаарх мэдээ мэдээллийг зурагт постер, лайв, видео хэлбэрээр ойлгомжтой байдлаар түгээж ажилласан байна.

Даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын гэрээ, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, э-даатгал аппликейшний талаар 2021 оны 01 дүгээр сард иргэдэд сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн даатгалын талаар танилцуулга анонсыг Нэгдсэн эмнэлэгт байршуулсан.
- Өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төвүүдэд ажиллаж иргэдэд эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний талаар сургалт сурталчилгаа хийж, гарын авлага тараасан.
- Орон нутгийн олон нийтийн радио болон “Саян” телевизээр Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн өөрчлөлт, ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоол, эмийн үнийн хөнгөлөлтийн талаар мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэж хүргэсэн.

- Орон нутгийн олон нийтийн радиод 2022 оны 02 дугаар сард “улсын болон хувийн эмнэлгүүдэд үзүүлж буй тусламж үйлчилгээ, төлбөрийн хэмжээ”-ний талаар ярилцлага өгсөн.
- Булган, Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвийн 50 гаруй эмч, ажилчдад ЭМДҮЗ-ийн шинэчлэгдсэн тогтоол, и-баримт апплейкшинээр ЭМД-ын шимтгэлийг хялбар төлөх боломжийн талаар танилцуулсан.
- ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилттэй холбоотой аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлэх үйлчилгээ авахад заавал шинжилгээ бүрдүүлэх, шинжилгээний төлбөрийг хувь хүнээр төлүүлж байгаа талаарх гомдол ирүүлснийг холбогдуулан олон нийтийн радиогоор хүргүүлж ажилласан байна.
- Өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төвүүдийн удирдлагуудад 2022 оны 07 дугаар сард ЭМДҮЗ-ийн 05 дугаар тогтоолын хэрэгжилт, 5, 6 дугаар сард нэхэмжлэлийн хяналтын үед гарсан алдаа зөрчлийг танилцуулж, сургалт зохион байгуулсан.
- Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ” өдөрлөгт оролцож иргэдэд мэдээлэл өгч, орон нутгийн “Дербес” телевизэд “Аймгийн хэмжээний эрт илрүүлэг одоогийн байдал” сэдэвт ярилцлага өгсөн байна.
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 100 гаруй эмч, мэргэжилтнүүдэд ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоол болон цахим нэхэмжлэлийн хяналтын талаар мэдээлэл хийж, санал солилцсон.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагсад болон хоригдлуудад Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, тусламж үйлчилгээний хөнгөлөлт эдлэх талаар 3 удаа хууль эрхзүйн зөвлөгөө өгч, сургалт хийж хамтран ажилласан байна.

“Эерэг хандлага-эрүүл оюутны эрүүл мэндийг дэмжих” сарын аяны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- МУБИС-ийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль, МСҮТ-ийн оюутнуудын судалгааг гаргаж, нийт 428 оюутны шимтгэл төлөлтийг нэг бүрчлэн шалгаж, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөөгүй байсан 100 оюутныг ЭМДШ-д хамруулах талбар сургуулийн захиргаанд албан бичиг хүргүүлж, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлүүлэх арга хэмжээ авчээ.
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран ЭМДШ-ийн талаар оюутнуудад сургалт явуулж, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан байна.

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 2021 онд иргэдээс 363 өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авсан байна. Үүнд:

Төр хариуцах шимтгэл төлөлттэй холбоотой 81, иргэний хурууны хээтэй холбоотой 249, элэгний В, С вирусийн илрүүлэг шинжилгээний алдааг программ дээр засварлах талаар 8, Улаанбаатар хотод очиж хагалгаа хийлгэсний төлбөрийг буцаахтай холбоотой 25 өргөдөл, гомдол хүлээн авчээ.

Төр хариуцах шимтгэл төлөлттэй холбоотой 81 өргөдлийг холбогдох газар хэлтсүүдэд уламжилж, иргэний хурууны хээтэй холбоотой 249 өргөдөл гомдлыг цахим системд даатгуулагчийг хурууны хээ уншуулахгүй бүртгэх шалгуур маягтыг бүртгэх, элэгний В, С вирусийн илрүүлэг шинжилгээний алдааг программд засвар хийхийг Мэдээлэл технологийн хэлтэст уламжилж, Улаанбаатар хотод хагалгаа

хийлгэсний төлбөрийг буцаахтай холбоотой гомдол гаргагч нарт ямар тохиолдолд төлбөрийг буцаан авах боломжтой талаар зөвлөгөө өгч ажиллажээ.

2022 онд төр хариуцах шимтгэл төлөлт, хурууны хээтэй холбоотой 436 хүсэлт, ЭМБ-ын тусламж үйлчилгээтэй холбоотой 60 санал, бусад 9 гомдол, нийт 505 өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авч холбогдох газар хэлтсүүдэд уламжилж, хэлтэс дээр шийдвэрлэгдэх санал гомдлыг тухай бүр шийдвэрлэж ажилласан байна.

Б.3. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа үр нөлөөтэй байна

Б3.1 Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тайлагнаж ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар дугаар сарын 09-ны өдрийн 13 дугаар хуралдааны тогтоолоор баталсан “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.2-т “Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна” гэсэн зорилт дэвшүүлсэн.

Энэхүү зорилтын хүрээнд эмнэлгийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргаж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах, аймагтаа оношлогдон, эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулахтай холбоотой гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулах, “Цахим монгол” арга хэмжээний хүрээнд орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх зэрэг 12 дэд зорилтыг дэвшүүлсэн байна.

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг үндэслэж, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг Аймгийн ИТХ-ын хуралдааны 2020 оны 12 сарын 09-ны өдрийн 14 дугаар тогтоолоор баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2-т “Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” зорилгыг дэвшүүлэн ажилласан байна. Энэхүү зорилгын хүрээнд 8 зорилт, 26 дэд зорилт дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

2.2.1-т “Иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах, эмчлүүлэх боломжийг бүрдүүлж, иргэдийн иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ” зорилтыг хэрэгжүүлэх 5 дэд зорилтыг,

2.2.2-т “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана” зорилтыг хэрэгжүүлэх 3 дэд зорилтыг,

2.2.3-т “Яаралтай тусламжийн чанар, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна” зорилтыг хэрэгжүүлэх 1 дэд зорилтыг,

2.2.4-т “Цахим-Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайны технологийг ашиглан цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ” зорилтыг хэрэгжүүлэх 3 дэд зорилтыг,

2.2.5-т “Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, эрсдэлийн сан байгуулахтай холбоотой гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлнэ” зорилтыг хэрэгжүүлэх 3 дэд зорилтыг,

2.2.6-д “Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ” зорилтыг хэрэгжүүлэх 1 дэд зорилтыг,

2.2.7-д “Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод туршлага судлуулах, сургалтад хамруулан чадавхжуулж, эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжинэ” зорилтыг хэрэгжүүлэх 4 дэд зорилтыг,

2.2.8-д “Эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, бусад салбарын оролцоог нэмэгдүүлэн эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна гэж тусгасан байна” зорилтыг хэрэгжүүлэх 4 дэд зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Дээрх хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг Аймгийн ЗДТГ нь жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор гаргаж, аймгийн ИТХ-ын тогтоолоор батлуулан ажилласан байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтсээс аймгийн хөгжлийн бодлогын баримт бичиг болох Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг дараа оны 2 дугаар сарын 01-ны дотор Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тайлагнан ажиллаж ирсэн байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг жил бүр аймгийн ИТХ-ын чуулганд танилцуулж, үнэлүүлсэн байна.

Хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтсээс Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 2022 онд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээ нь дараах байдалтай байна.Үүнд:

-Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөнд нийт 8 үндсэн зорилгын хүрээнд 21 зорилтыг хэрэгжүүлэх 118 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хангуулан ажиллаж, 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт ерөнхий үнэлгээгээр 91.2 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

Үүнээс Эрүүл мэндтэй холбоотой 1 зорилго, 12 зорилтын хэрэгжилтийн байдлыг үзэхэд 7 арга хэмжээ 100 хувь, 4 арга хэмжээ 90 хувь, 1 арга хэмжээ 70 хувьтай гэж дүгнэгджээ.

“Эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэн, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, бусад салбарын оролцоог нэмэгдүүлэн эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна” зорилтын хэрэгжилт нь 70 хувьтай байгаа нь цаашид хэрэгжилтийг сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнд орсон бөгөөд хариуцсан хэлтэс, агентлагууд хяналтад авч, зорилго, зорилт тус бүрд санхүүгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх, УИХ-ын гишүүд, яамдын дэмжлэгээр хэрэгжилтийг хангуулан ажиллах шаардлагатай байна гэдэг дүгнэлтэд хүрсэн байна.

- Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх “Хөгжилд тэмүүлсэн Баян-Өлгий” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4 жилийн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үндсэн 6 бүлэг, 22 дэд бүлгийн 111 зорилтыг хэрэгжүүлэх 311 арга хэмжээний 2022 оны хэрэгжилтийг ерөнхий дүнгээр 93.6 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн байна.

Үүнээс Эрүүл мэндтэй холбоотой зорилтын хэрэгжилтийг үзвэл дараах байдалтай байна:

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн Эрүүл мэнд-Эрхэм баялаг хэсгийн 1 үндсэн зорилгын хүрээнд 8 зорилт, 26 дэд зорилт дэвшүүлэн ажилласны 13 дэд зорилтын хэрэгжилтийг 100 хувь, 9 зорилтын хэрэгжилтийг 90 хувь, 2 зорилтын хэрэгжилтийг 70 хувь, 2 зорилтын хэрэгжилтийг 50 хувьтай гэж дүгнэсэн байна.

Баян-Өлгий аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд нийт үндсэн 6 бүлгийн 22 зорилтыг хэрэгжүүлэх орон нутгийн эдийн засаг, нийгмийн салбар чиглэлийн бодлогыг тодорхойлсон 123 арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт 88.78 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн байна.

Үүнээс эрүүл мэндийн хүрээнд “Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. ”дэвшүүлсэн зорилтын хүрээнд 5 арга хэмжээ төлөвлөсний 1 арга хэмжээ 50 хувьтай, 2 арга хэмжээ 90 хувьтай, 2 арга хэмжээ 100 хувьтай гэж дүгнэсэн байна.

“Иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах, эмчлүүлэх боломжийг бүрдүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг сумдад жилд 1 удаа тогтмол зохион байгуулна” гэсэн арга хэмжээ нь 50 хувьтай байгааг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Б3.2. Цахим программын хөгжүүлэлт, хүний нөөц дутмаг байдлаас шалтгаалж төлбөрийн нэхэмжлэлд бүрэн хэмжээгээр хяналт тавих боломж бүрдээгүй байна

Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс эрүүл мэндийн тогтолцоог үр дүнтэй, үр ашигтай болгох зорилтын хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудаас гэрээний дагуу худалдан авах тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг “Хяналтын журам батлах тухай” ЭМДҮЗ-ийн 2021 оны 05 дугаар тогтоол, ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-ын дагуу цахим хяналт болон нарийвчилсан хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хэдийгээр тус хэлтсээс чанарын болон төлбөрийн нэхэмжлэлд стандарт, журмын дагуу хяналт тавьж ажиллаж байгаа боловч ЭМДХ-ийн гаргасан тайлангаас харахад чанарын шалгуур хангаагүй нэхэмжлэл нь 2021 онд нийт нэхэмжилсэн тохиолдлын тоотой харьцуулахад 8 хувь, 2022 онд 4.2 хувьтай байна.

Нөгөө талаар ЭМДХ-ийн 3 мэргэжилтэн нь 2021 онд нийт нэхэмжилсэн 28,785.9 сая төгрөгийн тусламж, үйлчилгээний зардлаас эмч, байцаагчийн болон системийн хяналтаар шаардлага хангаагүй 4,337.3 сая төгрөгийн буюу 15 хувьд, 2022 онд нийт нэхэмжилсэн 35,163.9 сая төгрөгийн тусламж, үйлчилгээний зардлаас 2,897.3 сая төгрөгийн буюу 8.2 хувьд хасалт хийгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг илүү олгох эрсдэлийг бууруулсан байна.

Нийт нэхэмжилсэн тохиолдлын тооноос эмч, байцаагчид түүвэрлэгдсэн тоог авч үзэхэд 10-15%-д түүвэрлэгдэж хянагдаж байна. Түүвэрчилсэн хяналтаар илэрсэн зөрчлөөс эх олонлогийн хасагдалт бодогдож санхүүжилт олгогддог байна.

Үүнээс үзэхэд ойролцоогоор нийт нэхэмжлэлийн 30-35 хувьд чанарын хяналт хийгдэж байна гэж дүгнэж байна. Иймд чанарын хяналтыг илүү хүртээмжтэй хийхийн тулд хүний нөөцийг нэмэгдүүлэх, цахим программын хөгжүүлэх шаардлагатай байна.

Олон улсын туршлагаас үзэхэд нэхэмжлэлийн хяналтыг цахимаар хийх нь хамгийн үр ашигтай гэж үздэг. Жишээ нь БНСУ-д нийт нэхэмжлэлийг 100 хувь цахимаар, маш цөөн тохиолдолд хүний оролцоотой нарийвчилсан хяналт хийдэг байна.⁴ Манай орны хувьд 2022 оноос эхлэн өвчний түүхийг цахимжуулахаар программын хөгжүүлэлт хийгдэж эхэлсэн байна.

Аудитын дүнгээс үзэхэд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэл зүйн зааврын дагуу хяналт тавих, тусламж үйлчилгээний чанарын хяналт, үнэлгээг цахим мэдээ, мэдээлэлд суурилан нэгдсэн журмаар үр дүнтэй хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход холбогдох байгууллагууд анхаарах шаардлагатай байна.

Аудитын дүнгээр үзүүлээгүй тусламж, үйлчилгээнд нэхэмжлэл бичиж санхүүжилт авсан, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эмнэл зүйн удирдамжийн дагуу үзүүлээгүй, төлбөрийг нэхэмжлэлийг бодит байдлаас давуулан өндөр өртөгтэй тусламж үйлчилгээний код ашигласан зэрэг зөрчлүүд илэрч эрүүл мэндийн

¹ Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл стратегийн худалдан авалт, эмнэлгийн хагас бие даасан байдлыг бэхжүүлэх чиглэлээр үндэсний хэмжээний сургагч багш бэлтгэх сургалтын гарын авлага - 2022, хуудас 187)

3 байгууллагад 13.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, нөхөн төлүүлэхээр шийдвэрлэв.

Б.3.3. Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс ЭМДЕГ-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа 78 эрүүл мэндийн байгууллагын нэхэмжлэлийг хүлээн авч, нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлж, төлбөр тооцоог санхүүгийн хэлтэст хүргүүлж ажилласан байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- ЭМДЕГ-ын даргын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдөр баталсан “Орон нутаг дахь эрүүл мэндийн төвүүдийн гэрээний хэрэгжилтэд хяналт хийх” удирдамжийн дагуу Өлгий сумын “Шипагер”, “Мейрим”, “Рауан”, “Жансая” Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтийг шалгасан.
- ЭМДЕГ-ын Худалдан авах гэрээлэлтийн газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хяналт шалгалт хийх “ПГУ COV-SARS 2 шинжилгээ хийж буй зарим төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт үнэлгээ хийх удирдамж”-аар ЭМСайд, Сангийн сайдын 2021 оны “Журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай” А/387/99 дугаар хамтарсан тушаалын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторид хяналт шалгалт хийсэн.
- ЭМДЕГ-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн “Хяналт шалгалт хийх тухай” А/154 тоот тушаалын дагуу 6 эмнэлэгт хяналт шалгалт хийсэн.

ЭМДЕГ-тай гэрээтэй эрүүл мэндийн байгууллагуудад сургалт зохион байгуулж, хэлтсийн зүгээс газар дээрх хяналт хийж, арга зүйн туслалцаа үзүүлсний үр дүнд лавлагаа шатлалын эмнэлгүүдийн анхан шатны маягтын бүрдэлт, даатгуулагч иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарт ахиц гарсан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны хууль эрх зүйн орчин бүрдсэн байна
2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийг үр дүнтэй зохион байгуулж ажилласан байна
3. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн байна
4. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж, гүйцэтгэлийг тайлагнаж ажилласан байна
5. Өрх, сумын ЭМТ, төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 2022 оны гэрээг дүгнээгүй байна
6. Эрүүл мэндийн даатгалын төлбөрийн нэхэмжлэлд хяналт тавьж байгаа боловч цахим программын хөгжүүлэлт, хүний нөөц дутагдалтай байна
7. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн шинэчилсэн бодлогын үр дүнд эрүүл мэндийн байгууллагуудад олгож байгаа санхүүжилт нэмэгдсэн боловч үр нөлөө бага байна.
8. Малчин, айл өрх эрүүл тусламж үйлчилгээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна

Үндэсний аудитын газарт нэгдсэн тайлангаар холбогдох байгууллагуудад хүргүүлэх санал:

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх
2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг бодлогоор дэмжихэд анхаарах
3. Эрүүл мэндийн даатгалын цахим системийн уялдаа холбоог хангаж боловсронгуй болгоход анхаарах

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн Засаг дарга А.Камелият-д:

1.Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэгт Төлөөлөн удирдах зөвлөл байгуулж ажиллах;

II.Аймгийн эрүүл мэндийн хэлтсийн дарга Т.Майра-д:

2.Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх малчин айл, өрхийн тоо 2021-2022 онд төлөвлөсөн хүний тооноос 76-80 хувиар доогуур гарсан тул малчин айл өрхүүдийг эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлэх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

Өлгий сум, Баян-Өлгий аймаг, 83120
Утас/Факс: (976) 7042 2894,
Цахим шуудан: bayan-ulgii@emd.gov.mn,
Цахим хуудас: www.emd.gov.mn

2023.05.19 № 31
танай _____ -ны № _____ -т

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөөнд хийсэн дүгнэлт тайлантай танилцав.

Танай аудит нь холбогдох хууль журмын дагуу хийгдсэн гэж үзэж байна. Тайлантай холбоотой ямар нэгэн саналгүй болно.

ДАРГА

Д.МАЙРА





БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/10

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө" сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар тавигдсан төлбөрийн актыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, зөвлөмж, төлбөрийн актын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс /Т.Майра/-т зөвлөсүгэй.

4. Аудитын дүнгээр өгсөн зөвлөмж, төлбөрийн актыг бүртгэлд авч хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг ахлах аудитор /У.Ербол/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.



М.ХУАНГАН

D:\bichig hereg\2023\tushaal.doc

Баян-Өлгий аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга, тэргүүлэх
аудиторын 2023 оны 05 дугаар
сарын 19-ны өдрийн 440 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Төлбөрийн	
		Тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн Нэгдсэн эмнэлэг	1	9590.0
2	"Нурлы" хувийн эмнэлэг	1	1452.0
3	"Жаншарапат" хувийн эмнэлэг	1	2050.2
	НИЙТ ДҮН	1	13.092.2